

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг*

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-3
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	4-30
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай/	4
2.Боловсролын салбарын эрх зүйн орчин шинэчлэгдсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний ерөнхий мэдээлэл, түүнчлэн боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн талаарх Боловсролын сайдын мэдээлэл сонсох	5-30

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
12 дугаар сарын 18-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрам ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 36 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: О.Батнайрамдал, А.Ганбаатар, Г.Дамдинням, Ц.Мөнхтуяа,  
Д.Рэгдэл, Г.Хосбаяр;  
Эмнэлгийн чөлөөтэй: О.Саранчулуун.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай  
Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ч.Ундрам тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ч.Ундрам:** “Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 1  
Бүгд: 8  
87.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Г.Хосбаяр нарыг нэмэв.

Уг асуудлыг 14 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Боловсролын салбарын эрх зүйн орчин шинэчлэгдсэнтэй  
холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний ерөнхий мэдээлэл,  
түүнчлэн боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн талаарх  
Боловсролын сайдын мэдээлэл сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал М.Итгэл, Боловсролын үнэлгээний төвийн захирал Г.Гантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Х.Хэрлэн нар байлцав.

Боловсролын салбарын эрх зүйн орчин шинэчлэгдсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний ерөнхий мэдээлэл, түүнчлэн боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн талаарх мэдээллийг Боловсролын сайд П.Наранбаяр танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Ж.Галбадрах, Н.Алтаншагай, Ш.Бямбасүрэн, Д.Бум-Очир, Ч.Ундрам нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал М.Итгэл, Боловсролын үнэлгээний төвийн захирал Г.Гантуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Боловсролын салбарын эрх зүйн орчин шинэчлэгдсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний ерөнхий мэдээлэл, түүнчлэн боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн талаарх Боловсролын сайдын мэдээллийг сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 34 минут үргэлжилж, ирвэл зохих 15 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 10 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ч.УНДРАМ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр,  
Лхагва гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим 14 цаг 36 минут.

### **БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ч.Ундрам:** Гишүүнээс 8 гишүүн ирж ирц бүрдсэн учраас хуралдааныг эхлүүлье. Гишүүдийн ирцийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай ирсэн байна, Дуламын Бум-Очир ирсэн байна, Шинэбаярын Бямбасүрэн ирсэн байна, Жанчивын Галбадрах ирсэн байна, Мягмардашийн Сарнай ирсэн байна, Чинбатын Ундрам ирсэн, Бадарчийн Хэрлэн ирсэн, Сүхбаатарын Эрдэнэбат ирсэн байна, Отгоншарын Батнайрамдал чөлөөтэй, Амгаланбаатарын Ганбаатар чөлөөтэй, Гонгорын Дамдинням чөлөөтэй, Цэндсүрэнгийн Мөнхтуяа чөлөөтэй, Дүгэрийн Рэгдэл чөлөөтэй, Отгоны Саранчулуун өвчтэй, Ганбатын Хосбаяр чөлөөтэй байна.

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

Нэгдүгээрт, “Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл батална.

Хоёрдугаарт, Боловсролын салбарын эрх зүйн орчин шинэчлэгдсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний ерөнхий мэдээлэл, боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн талаарх Боловсролын сайдын мэдээлэл сонсоно. Энэ хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Ийм учраас хэлэлцэх асуудлаа баталлаа.

1 Нэгдүгээрт, “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг тус тус үндэслэн БСШУС-ын байнгын хорооноос тогтоох нь:

БСШУС-ын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Улсын Их Хурлын гишүүн Хосбаяр нарыг нэмсүгэй гэсэн ийм тогтоолын төслийн өөрчлөлт байна. Тэгэхээр энэ дээр бид нар Дэгийн тухай хуулиараа санал хураалт хийнэ. Энэ нөгөө төрийн өмчийн ЕБС, дотуур байр, цэцэрлэгүүдийг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар хангах ийм ажлын хэсэг дээр саяын 2 Улсын Их Хурлын гишүүн өөрсдийн саналаараа оръё гээд санал өгсөн учраас бид нар дэгээрээ заавал санал хураадаг учиртай байгаа учраас санал хураая аа.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн 87.5 хувь дэмжсэн учраас бас дэмжигдсэнд тооцлоо.

Дараагийн асуудал. Боловсролын салбарын эрх зүйн орчин шинэчлэгдсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний ерөнхий мэдээлэл боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн талаар Улсын Их Хурлын гишүүн Боловсролын сайд Наранбаяр танилцуулна.

Ажлын хэсгийг оруулъя. Боловсролын сайд Наранбаяр, Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Оюунаа, Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал Итгэл, Боловсролын үнэлгээний төвийн захирал Гантуяа гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна аа.

Танилцуулгаа эхлээрэй.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Энэ танилцуулга юун дээрээ орчихсон байгаа юу тэ?

Эрхэм хүндэт гишүүд ээ,

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Боловсролын хуулиудын хэрэгжилт, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, үнэлгээний нөхцөл байдлын талаар танилцуулъя аа.

Боловсролын ерөнхий болон дагалдах хуулиуд 2023 оны 7 дугаар сарын 7-нд Улсын Их Хурлаар батлагдсанаас хойш засаглал удирдлага, тэгш хамран сургалт, сургалтын хөтөлбөр, багшийн хөгжил, цахим шилжилт, үнэлгээ гэсэн 6 чиглэлээр хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нэгдүгээрт боловсролын засаглал удирдлагыг илүү мэргэшсэн бодлогын тогтвортой хэрэгжилтийг хангах олон талын оролцоог хангах зорилгоор Үндэсний болон мэргэжлийн зөвлөлийг Засгийн газрын 2023 оны 305 дугаар тогтоолоор байгууллаа.

2024 оны өнөөдрийн Засгийн газрын бас тогтоолоор Боловсролын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон. Засгийн газрын өнөөдрийн хуралдаанаар бид бас нэмэлт өөрчлөлт оруулж бүрэлдэхүүнийг нэмсэн байгаа. Боловсролын үндэсний зөвлөл байгуулагдсанаас хойш хэд хэдэн хурал зохион байгуулагдаж хуульд заасан үүргийн дагуу сургуулийн өмнөх ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг хэлэлцэж, Засгийн газрын 176 дугаар тогтоолоор батлуулсан нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг эхлүүлэх боломжийг бидэнд олголоо.

2025 оны 1 дүгээр улиралд сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн явц туршилтын эхний үр дүнг хэлэлцүүлэх бэлтгэлийг бид ханган ажиллаж байна. Хуульд заасан эрхийн хүрээнд сургуулийн өмнөх ерөнхий боловсрол мэргэжлийн болон техникийн боловсрол Дээд боловсролын зөвлөлүүдийг байгуулж холбогдох журмыг батлан хэрэгжүүлж байна аа. Эдгээр мэргэжлийн зөвлөл бүр өнгөрсөн хугацаанд хөтөлбөр, сурах бичгийн шинэчлэл, элсэгчийн квот гэх мэт асуудлуудыг хэлэлцэж шийдвэрүүдийг гаргаад байна. Сургалтын байгууллагын зөвлөл, Удирдах зөвлөлийг байгуулж холбогдох дүрэм журмыг батлан хэрэгжүүлж байна аа. Сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагад мэргэшсэн байхтай холбоотой шаардлагыг хуульд тусгасан гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Энэ чиглэлээр

сургалтын байгууллагын удирдах ажилтны шаардлагын дагуу дүйцүүлэх журмыг батлан ажиллаж байна аа. Тэгш хамран сургах, тэгш хамруулах сургалтын хэрэгжилтийг боловсролын бүх түвшинд хангаж ажилласнаар энэ хичээлийн жилд Лам хийдэд шавилан сууж буй эрх нь хязгаарлагдсан, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй болон гадаад дахь Монгол хүүхэд залуучуудыг боловсролд тэгш хамруулж байна аа.

Тухайлбал Монгол Улсын болон гадаад оронд сүм хийдэд шавилан сууж буй 500 гаруй хүүхдүүдийг нийслэлийн ерөнхий боловсролын 112 дугаар сургуульд төвлөрүүлэн ерөнхий боловсрол эзэмшүүлэх шийдвэрийг гаргаж сургалтын төлөвлөгөө хөтөлбөрт тохируулга хийсэн. Эрх нь хязгаарлагдсан залуучууд анх удаа элсэлтийн шалгалт өгч дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн цахимаар суралцаж байна аа. Хөгжлийн бэрхшээлтэй 2-18 насны хүүхдийн 78.9 хувь нь сургуулийн өмнөх ерөнхий боловсролд хамрагдаж байгаа ерөнхий боловсролд хамрагдаж байгаа бөгөөд танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудад цогц дэмжлэг үзүүлэх дүрмийг бид Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамтай хамтран баталж байна аа.

Тэгш эрх хамруулах боловсролын хэрэгжилтийг хангах багш болон бусад ажилтны хангалтыг нэмэгдүүллээ. Эрэлттэй мэргэжлийн чиглэлд хэл засалч, хөдөлгөөн засалч гэх мэт мэргэжлийг оруулснаар гадаад дотоодын их дээд сургуульд оюутан элсүүлэхэд тэтгэлэг зээл олгох боломжтой болов. Цэцэрлэг ЕБС-ийн тэгш хамран сургалтыг дэмжих зорилгоор багшийн туслах ажиллуулж эхэлснийг тэмдэглэн хэлэхэд таатай байна аа.

Түүнчлэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд заасны дагуу энэ хичээлийн жилд суралцагчийн эрүүл мэндийн үзлэгийг ЭМЯ-тай хамтран зохион байгуулж одоогийн байдлаар нийслэлийн хүрээнд 6 настнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамрууллаа. Боловсролын ерөнхий хуульд бүх түвшний боловсролын уялдаа хангах төгсөгчийн ур чадварыг ажлын байрны шаардлагатай нийцүүлэх зорилгоор мэргэжлийн шаталсан бүтцийг тусгасан. Энэ бүтцийг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр Юнейскогийн мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж Засгийн газрын 2024 оны 227 дугаар тогтоолоор батлууллаа. Одоо бид Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран Хөдөлмөрийн тухай хуулийн 17.3-д заасны дагуу энэ бүтцэд мэргэжлийг бүртгэх баталгаажуулах журмыг боловсруулах хамтарсан ажлын хэсгийг байгуулж байна.

Эрхэм гишүүд ээ, Боловсролын багц хуулийн хамгийн чухал шинэчлэлийн нэг нь багшийн хангалтыг нэмэгдүүлж чанарыг сайжруулах явдал юм аа. Энэ шинэчлэл болон багш нарын 8 дугаар хурлаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор багшийн 3 тулгуурт бодлого арга хэмжээг Засгийн газрын 2024 оны 192 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна аа. Багшийн хангалт, чанарыг нэмэгдүүлэх зорилгоор багшлах эрх олгох хөрвөх сургалтын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор багш удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах журмыг батлан хэрэгжүүлж байна аа.

Түүнчлэн багшийн дутагдлыг нөхөх чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж ажиллаж байна. Тухайлбал багшийн мэргэжлээр төгссөн боловч багшийн ажил эрхлээгүй байгаа хүний нөөцийг ашиглах,

Хоёрдугаарт, тэтгэвэрт гарсан багш нарыг бага цагаар багшлуулах,

Гуравдугаарт, шинжлэх ухааны чиглэлээр их дээд сургууль амжилттай төгссөн эсвэл 3-аас 4 дүгээр ангид суралцаж байгаа оюутнуудыг багшийн ажилд татан оролцуулах. Сургалтын цагийн норм 19 цагт хүрдэггүй зарим багш нарыг хөрвүүлж ижил төстэй хичээл заалгах, багш бэлтгэх их дээд сургуулийн 4 дүгээр ангийн оюутнуудыг дадлагажигч багшаар ажиллуулах,

Зургаадугаарт, Цахим сургалтыг багшийн дутал өндөр байдаг хичээл, сургалтад илүү эрчимтэй хэрэгжүүлэх зэрэг болно оо. Багшийн ажлын ачааллыг бууруулах чиглэлээр бага ангийн 44-өөс дээш хүүхэдтэй бүлэгт багшийн туслах ажиллуулах шийдвэрийг гаргаж Улаанбаатар хотын ЕБС-ийн 44-өөс дээш хүүхэдтэй 157 бүлэгт ажиллах багшийн туслахыг МУБИС-ийг түшиглэн сургаж байна аа. Багшийн нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр 2024 онд багш мэргэжлээр суралцагчдад 14.5 тэрбум, багш, ажилтны хүүхдийн сургалтын төлбөртэй холбоотой 2024 оны 10 дугаар сарын байдлаар 233 суралцагчдад нийт 552.8 сая төгрөг 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 673 суралцагчид 2 тэрбум 692 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцлоо.

Хөдөө орон нутгийн багшийн тэтгэмжид 105.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийлээ. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоог шинэчлэн сургуульд суурилсан багш манлайлсан мэргэжил дээшлүүлэх үзэл баримтлалыг хэрэгжүүлж байна аа. Хуульд заасны дагуу багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих төвүүдийг багш бэлтгэх их дээд сургуулийн дэргэд байгуулах шийдвэрийг гаргаж Кембрижийн их сургуулийн багшийн хөгжлийн сургалтад 21 багш, судлаачийг сургаж бэлтгэлээ. Багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийн журмыг боловсруулж оролцогч талуудын хэлэлцүүлгүүдийг эдүгээ хийж байна.

2025 оноос багш удирдах ажилтнууд шинэчилсэн байдлаар мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа сургалтад хамрагдах ба орон нутаг, сургууль, багш нар өөрсдийн хэрэгцээндээ үндэслэн зохион байгуулах боломжийг олгоно. 2024-өөс 2028 онуудад багшийн 3 тулгуурт бодлогын хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж үр дүнд хүрэхээр төлөвлөөд байна аа. Боловсролын цахим шилжилт Боловсролын багц хуулийн 5 дахь шинэчлэл бөгөөд хамтарсан Засгийн газрын тэргүүлэх зорилт юм аа. Боловсролын цахим шилжилтийн хүрээнд холбогдох журмыг батлан хэрэгжүүлж байна. Юуны өмнө боловсролын их өгөгдлийн аналитик системийг хөгжүүлж бодлого төлөвлөлтөд ашиглаж эхлээд байна аа.

Хуульд заасан цахим сургалтын байгууллагыг байгуулах зорилгоор мэдлээ сургуулийн үйл ажиллагааг 2023 онд эхлүүлж энэ хичээлийн жилд 10-аас 12 дугаар ангийн 17 мянга гаруй суралцагч сонгон судлах хөтөлбөрөөр хичээллэж байна аа. Энэхүү мэдлээ сургууль өнөөдөр виртуал сургууль болж бас хөгжиж байгаа. Боловсролын салбарт хэрэглэж байгаа мэдээллийн сангуудын дундын мэдээллийн солилцоог сайжруулах ашиглаж байгаа платформуудад нэгдсэн стандарт мөрдүүлэх зорилгоор хуульд заасан журам, стандарт, шаардлагуудыг боловсруулан батлуулж тус журам нь ХЗДХЯ-нд хянагдаж эдүгээ манай яаманд буцаж ирсэн байгаа. Сургалтад цахим технологийг нэвтрүүлэх багшийн ачааллыг бууруулах зорилгоор ЕБС-ийн сурах бичгийг цахимжууллаа.



Бага ангийн 33 сурах бичгийг интерактив болгосон ба 6-аас 12 дугаар ангийн байгалийн ухаан математикийн сурах бичгийг цахим контентоор баяжуулах ажлыг эхлүүлээд байна аа. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр сурах бичгийн шинэчлэлийг батлагдсан төлөвлөгөөний дагуу эхлүүлээд байна. Сургалтын хөтөлбөр сурах бичгийн багийн бүрэлдэхүүнийг нээлттэй байдлаар хуульд заасны дагуу Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн сонгон шалгаруулсан бөгөөд олон талын оролцоотой багууд ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар сургуулийн өмнөх болон бага боловсролын хөтөлбөр шинэчлэгдэж улсын хэмжээнд 27 сургууль 18 цэцэрлэгт тохирц нийцлийг сайжруулах ажил явагдаж байна аа. Энэ удаагийн шинэчлэлээр сурах бичиг нь дагалдах дасгал ажлын дэвтэр, багшийн номтой байх бөгөөд Байнгын хороонд эхний хэвлэлтүүдийг багцаар нь хүргэсэн байгаа.

Нарийвчлан зарим нэг шинэчлэлээс дурдахад бага ангид зарим хичээлийг интеграцчилсан, цагаан толгойн үсгийн дараалал өөрчлөгдсөн, компьютерын ухаан гэх мэт хичээлүүд нэмэгдэж орж байгааг дурдах нь зүйтэй.

Боловсролын хуулийн шинэчлэлийн томоохон хэсэг нь санхүүжилтийн шинэчлэл.

Энэ хуулиар боловсролын салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлсэн бөгөөд 2025 онд бид төсвийг батлуулаад ажиллаж байна аа. Хуульд заасан итгэлцүүрийг тооцсон анги бүрд харилцан адилгүй байх хувьсах зардлыг батлан хэрэгжүүлж байна аа. Багц хуулийн шинэчлэлийн 6 дахь нь үнэлгээний шинэчлэл бөгөөд багш сургалтын байгууллагын гүйцэтгэлийн олон улсын үнэлгээнүүд шинээр орж ирснийг та бүхэн мэдэж байгаа. Элсэлтийн шалгалтын журамд өөрчлөлт оруулж монгол хэлийг 10 дугаар ангиас эхэлж өгөх энэ шалгалтыг жилд 2 удаа зохион байгуулдаг болсон. Ирэх жилийн элсэлтийн шалгалтын их дээд сургуульд элсэх босго оноог мөн өөрчилж ахиуллаа. Цэцэрлэг сургуулийн багш байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг 2022 оноос эхлэн зохион байгуулсан бөгөөд хэрэгжилтийг сайжруулах гарсан сул талыг сайжруулах зорилгоор арилгах зорилгоор 2024 оны 9 дүгээр сараас эхлэн энэ үнэлгээний зохион байгуулалт шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулан туршилтыг хөдөө орон нутгийн цэцэрлэг, сургуулиуд дээр бид зохион байгуулж байна аа. Үүний дүнд гүйцэтгэлийн үнэлгээний журамд өөрчлөлт орж өмнө нь гарсан сул талыг сайжруулах болно. Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухайд хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр өртөгт суурилсан хувьсах зардлыг батлуулан хэрэгжүүлж байна. Энэ хичээлийн жилээс эрчим хүчний мэргэжлүүдээр хосмог сургалтыг өөрөөр хэлбэл ажиллангаа суралцах, суралцангаа ажиллах сургалтыг Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн тахимтай хамтран Германы хамтын ажиллагааны байгууллагын төсөлтэй хамтран хэрэгжүүлж эхэллээ. Хөдөлмөрийн зах зээлд хүний нөөц дутагдалтай байгаа. Мэргэжлийн сургалтыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагатай эхлэн хэрэгжүүлж байна аа.

Тухайлбал мэдээлэл технологийн дунд түвшний мэргэжилтэй ажилтныг бэлдэх Персон би Тек хөтөлбөрийг хэрэгжүүлж байна аа. Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, их дээд сургуулийн удирдах зөвлөлийг шинэчлэн зохион байгуулан ажиллаж байна. Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбийг Таймс Хайер Эдьюкэйшн байгууллагатай хамтран хийж баталгаажууллаа. Хөтөлбөрт тавигдах шаардлагыг шинэчлэн баталснаар сургалтын хөтөлбөрийн

чанарыг сайжруулах төгсөгчийн эзэмших ур чадварыг ажлын байрны шаардлагад нийцүүлэхэд ахиц гаргана гэдэгт бид итгэлтэй байна аа.

Бүх хуулийн хэрэгжилтийг нэг бүрчлэн танилцуулахад багагүй хугацаа шаардана аа. Гэсэн хэдий ч голлох шинэчлэлийн ажлуудын талаар та бүхэнд бид мэдээлэл хүргэхийг хичээлээ. Сургалтын хөтөлбөр, сурах бичгийн шинэчлэл, үнэлгээтэй холбоотой тодруулах мэдээллийг өгөхөөр Боловсролын судалгааны Үндэсний хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын ерөнхий газрын удирдлагууд энд хүрэлцэн ирсэн байгааг дуулгая аа.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

**Ч.Ундрэм:** Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой гишүүдээс асуулт асуух хүн байвал нэрсээ өгнө үү? Бямбасүрэн гишүүнээр тасаллаа. Орчихсон байна тэр хамгийн дээр байх шиг байна.

Энэ дээр харагдахгүй байх юм юу билээ? Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

**С.Эрдэнэбат:** Энэтэй холбоотой бас нэг хэдэн асуулт бас асууя. Одоо удахгүй бас хүүхдүүдийн хичээл сургалт амралтын үе бас эхэлнэ. Энэ үеэр энэ боловсролын салбарын багш ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах энэ чиглэлээр ЭМЯ-тай гэдэг юм уу энэ ханиад томуу юутай үед хамтарч ажиллах ийм боломж бололцоо талаар ярьж байгаа юу? Олдож байгаа богинохон хугацаанд бас энэ хүмүүсийг заавал очер дугаар гэлтгүй бас энэ боловсролынхоо салбарын хүмүүсийг энэ хүүхдийн амралтыг далимдуулаад бас хамруулчих ийм шаардлагатай.

Дээрээс нь энэ саяын төсөв дээр энэ хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой зардлууд нэлээн хасагдах шиг болсон. Тэгэхээр энэ дээр Боловсролын яам маань одоо тэр даатгалыг нь хамруулдаг байна уу энэ чиглэлээр бас нэг тодорхой арга хэмжээ хийвэл бас их зүгээр байгаа юм гэдгийг бас хэлмээр байна.

Хоёрдугаарт, багш нарын тэр гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой санал гомдол маш их ирэх юм. Тэгээд энэтэй холбоотойгоор яг энэ жилийн төсөвтэй холбоотойгоор бас эргээд хүндрэлүүд гарах уу? Энийг хэрхэн зохицуулж байгаа вэ? Хичээлийн хоцрогдол бас нэлээн их байна аа. Тодорхой хичээлүүдийг үздэггүй багш байхгүйн улмаас ерөөсөө үздэггүй тийм сум зарим сургууль юмнууд байна. Тэгэхээр энийг бол бас тодорхой ур чадвар сайтай улсын хэмжээнд нэлээн өндөр үнэлгээтэй заах аргачлал сайтай ийм багш нараар хичээл цахим онлайн байдлаар заагаад, хүүхдүүд нь өөрсдөө үздэггүй бол тэр багшийнхаа хичээл рүү ороод хаанаас ч гэсэн ороод үзэх ийм боломж бололцоогоор нь хангаж өгөх ийм боломж байгаа юу? Ялангуяа энэ цахим шилжилттэй холбоотойгоор би бас асуумаар байна.

Дээрээс нь энэ манай Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй холбоотой бас юу яригдлаа. Насанд хүрээгүй хүүхдүүдийг хосолмол мэргэжлийн тогтолцоогоор сургах гэж байгаа. Хууль нь өөрөө насанд хүрээгүй хүүхдүүдийг хосмог гэхээрээ 50 хувь нь практик дадлага танхимаар үзэх онол үзэх.

Тийм учраас энэ дээр хүүхдийн хөдөлмөрийн асуудал яригддаг байхгүй юу. Практик дадлагаар хичээллүүлж байна гээд хүүхдүүдийг янз бүрийн барилга дээр ажиллуулах ч гэдэг юм уу янз бүрийн ажлуудыг хийгээд хөдөлмөрийг нь мөлжөөд

байдаг асуудал гардаггүй учраас тэр. Германы GIZ гэдэг байгууллага энэ эцэг эх, хүүхдийн асран хамгаалагч, дээрээс нь үйлдвэрчний эвлэлийн байгууллагыг оролцуулж тэр хүүхдийн хөдөлмөрийг ашиглаж байна уу, үгүй байна уу гэдэг дээр нь хяналт тавьж гуравласан гэрээгээр ажиллах ёстой байдаг юм. Тэгээд сая сайдын хэлснээр зөвхөн та Худалдаа Аж Үйлдвэрийн танхимтай хамтраад хийчихнэ гэдэг ийм байдлаар ярих шиг болох юм. Би өмнө нь бас уулзаж байсан юм. Тэр GIZ-гийнхэнтэй. Тэгэхээр энэ тал дээр бас хууль дээр нь хүртэл бас тийм зүйлүүд байгаа гэдэг талаар тодруулж асууя.

Хамгийн сүүлийн асуулт тэтгэвэрт гарсан багш нарыг нэмээд асуучихъя.

**Ч.Ундрам:** Нэмээд нэг минут өгье.

**С.Эрдэнэбат:** Тэтгэвэрт гарсан багш нарыг ажиллуулахаар энэ аудитаас дүгнэлт ирж байна гээд бас олон багш нар хандаад байх юм. Олгодог байсан бүх нэмэгдлүүдийг нь олгохгүй гээд ингээд ийм чиглэл ирчихсэн. Зөвхөн үндсэн цалингаараа ажилла гэдэг нэг иймэрхүү байдалтай байхаар энэ чинь зөрчилддөггүй юу. Энэ тал дээр нэг аудиттай учраа олох гээд би бичиг явуулсан тэгээд хариу нь ирээгүй. Боловсролын яаман дээр яг энэнтэй холбоотой ямар гомдол саналууд байна вэ? Мөн дээрээс нь боловсролын хууль дээр байгаа хуулиас гадна зохицуулахгүй олон асуудлыг салбарын хамтын хэлэлцээрээр зохицуулсан байгаа. Дундаж улсын цалинд хүргэнэ мөн хэлэлцээр дээр маш олон зүйлүүдийг би тохирсон гэж ойлгосон. Тэгээд энэний хэрэгжилтийг хэрхэн хангах вэ? Энэ чиглэлээр бас олон сургуулиудаас ажилчдаас бас саналууд ирж байгаа юм аа. Энэ талаар бас та товч мэдээлэл өгнө үү? Баярлалаа.

**Ч.Ундрам:** Наранбаяр сайдын микрофоныг өгье.

**П.Наранбаяр:** Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Эрүүл мэндийн үзлэгийн тухайд бол яг энэ нэг сард одоо ингээд ирэх 7 хоногийн 23-ны өдрөөс нэг дэх өдрөөс эхлээд хагас бүтэн сайн орвол 21-ээс эхлээд бага сургуулийн 1, 2 дугаар анги амарна. Түүний дараа яг 7 хоногтоо 5 хоног хичээллээд дараагийн 7 хоногт нь бол дунд болон 3, 4, 5 дугаар ангийн хүүхдүүд амарна. Тэрний дараагийн 7 хоногт ахлах сургууль 12 сарын 30-аас 1 сарын 3-ны хооронд цахимаар хичээллээд ингээд бүрэн амралт нь эхэлнэ ээ. Энэ хугацаанд яг 1 сарын 6-аас 5 хоног яг багш нар нэг дэхээс авхуулаад 5 дахийг дуустал яг ямар ч ажил зохион байгуулахгүй ээлжийн амралтынхаа 5 хоногийг амрах ёстой. Энийг бол ингээд авчхаж байгаа. Тэгээд тэрний дараа эрүүл мэндийн үзлэгт үзүүлэх асуудлыг бид дэмжиж ажиллана аа.

Өнөөдөр нэг 4 төрлийн л үзлэгийг хийгээд байгаа. Энийг нь олшруулах багш нар өөрсдөө үзүүлэе гэсэн энэ эрүүл мэндийнхээ тэр төрлийн үзлэгт оруулах тал дээр нь бид ЭМЯ-тай эрт илрүүлгийн энэ асуудлаар яг ид хэлэлцэж байна. Тэгээд ЭМЯ-ны санал ороод ирэхээр бид нар энэ үзүүлэх энэ юуг нь ихэсгээд тоог нь олшруулаад багш нартаа илүү таатай байхаар зохион байгуулаад явна аа. Багш нартаа илүү сонголттой болгох чиглэлээр. Хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал яг төсөв хэлэлцэх үеэр та бас хөндөж байсан. Бид бас мартаагүй ээ. Энэ багшийн ажлын байрны стандартыг бид нар бас сахиулах энэ чиглэлээр бас энэ стандартыг сахиулах чиглэлээр санхүүжилт олгож байгаа. Энэ хүрээндээ шийдвэрлээд явж

болохоос гадна ажлын байрны эрсдэлийн үнэлгээг бас хийх ажлыг мөн Улсын Их Хурлын Тамгын газартай хамтраад энэ судалгааг эхлүүлэхээр ярьж байна.

Сая батлагдсан төсөв бол 2024 оны төсвийн урсгал зардалтай нь харьцуулахад нийтдээ нэг 550 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ийм төсөв байгаа 2024 онтой нь харьцуулахад. Тийм учраас ямар нэгэн бол хүндрэл гарахааргүй байгаа. Юуны хувьд бол зарим нэг сумдад бол мэргэжлийн багш дутсанаас болоод хичээл заагдахгүй, хүүхэд үзэхгүй ингээд хохирч байгаа тал байсныг бол бид нар мэдлээ сургуулиар нь өгч байгаа. Энэ мэдлээ гээд цахим сургууль байгаа. Энэ дээр өнөөдрийн байдлаар 17 гаруй мянган хичээл бий болчихсон. Тэнд чинь бүртгэлтэй 400 гаран багш ингээд заагаад явж байгаа тэгээд харин бас энэ тэнд бас илүү ч виртуал орчны сургууль болгосон ийм хувилбар нь бас бий болж байгаа.

Гуравдугаарт нь бол хосмог мэргэжлийн асуудлыг хосмог сургалтын асуудлыг та хөндөж байна.

Өнөөдөр энд хамрагдаж байгаа нь яг хөдөлмөрийн насны яг хөдөлмөр эрхлэх боломжтой насанд Хөдөлмөрийн хуулиараа хүрсэн ийм өсвөр насныхан бас хамрагдаж байгаа. Өнөөдрийн байдлаар нийт хичээлийнх нь эхний жил нь 70 хувь нь танхимд хичээллэх юм. Тэрний дараа 50, 50 болоод тэрний дараа 30 хувь нь танхимд 3 дахь жил дээрээ 70 хувь нь яг тэр ажлын байран дээрээ гэж ингэж явна. Бид бас энэ хүүхдийн эрхийг хамгаалах хөдөлмөрийн хүүхдийн хөдөлмөрийн хүүхдийн эрхлэх хөдөлмөрийг хориглосон энэ конвенцын хүрээний энэ асуудлыг шийдэж байгаа гэдгийг хэлье. Үйлдвэрчний эвлэлийн оролцоог бол хаа хаанаа хангаад явахад бэлэн байна аа.

Дөрөвдүгээрт нь тэтгэвэрт гарсан багш нарын асуудлыг та хөндлөө. Бид илүү цагийг нь төлөөд явдаг. Хөдөлмөрийн хуулиараа бусад нэмэлтүүд юм нь олгогдохгүй ингээд явж байгаа. Ийм байгаа. Баярлалаа.

**Ч.Ундрам:** Хариулт хангалттай юу? Эрдэнэбат гишүүнд нэг минут өгье.

**С.Эрдэнэбат:** Хөдөлмөрийн хуулиараа бусад нэмэгдэлтүүдийг нь олгохгүй явж байгаа гэдэг чинь та яг тодруулаад хэлээч? Хөдөлмөрийн хуулиар тэтгэвэрт гарчихсан хүнийг цалин хөлсийг хязгаарлах үндэслэл болохгүй гэдэг заалт байдаг. Тэтгэвэрт гарсан тэр хүнийг ажиллаж байгаа нөхцөлд бусад цалин хөлс нэмэгдэл урамшууллуудыг хязгаарлах үндэслэл болохгүй гээд нэг үг байдаг. Аудитынхан болохоор юу гэж үзээд байна вэ гэхээр тэр ажилласан жилийн нэмэгдэл гээд бусад зарим зүйлүүдийг нь ингээд хасах ёстой гээд өөрсдөө хууль зохиогоод ингээд яваад байгаа юм. Энэ дээр нэг аягүй олон зөрчил байна. Тэгэхээр энэ тал дээр ялангуяа хүний нөөцийн дутагдалтай энэ үед энэнээс болоод бас ахмад сайн багш нар маань ажиллахгүй байх ийм бас нөхцөл байдал үүсэх вий.

**Ч.Ундрам:** Хэн хариулах вэ? Наранбаяр сайд.

**П.Наранбаяр:** Тийм сая миний хариултад тэр хөдөлмөрийн хуулиар гэсэн үг хэлсэн байна. Тэгэхээр таны яг уншсан энэ заалт үнэн. Яг олгогдохгүй байгаа нэмэгдэл нь гэвэл орон нутгийн нэмэгдэл. Орон нутгийн нэмэгдлийг нь олгож байгаа. Олгогдохгүй байгаа нэмэгдэл юу вэ? Ажилласан жилийн нэмэгдэл ажилласан жилийн нэмэгдлийг нь олгохгүй байгаад өөр ямар юм байна олгохгүй байгаа.

Ер нь нэмэгдлүүдийг нь олгогдоод явж байгаа гэсэн ийм байна. Би тэгэхдээ яг ингээд хөдөө орон нутгаар яг энэ тэтгэвэртээ суучихсан ийм багш нартай уулзаад явж байхад бол бас тэд яг ийм санал тавьдаг. Бидний ингээд яг ид ажиллаж байсан үетэй харьцуулахад нэмэгдлүүд бүрэн олгогдохгүй байна гэсэн ийм байдаг. Бид аливаа зүйлийг хуулийн хүрээнд л авч үзнэ. Энэ асуудлаар бид нар бас тухайлан судлаад танд бас хариу барья.

**Ч.Ундрам:** Тэгэхээр Боловсролын яаман дээрээс энэ асуудлаар тухайлан судлаад хариу хүргүүлэх нь байна тиймээ.

Галбадрах гишүүн асуулт асууя.

**Ж.Галбадрах:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Танилцуулгатай танилцлаа. Тэгээд тодорхой, ойлгомжтой байна бас нэлээн нэлээн шинэлэг юмнууд хийж байгаа нь бас харагдаж байна гэж бодож байна. Тэгээд хэд хэдэн асуулт байна. Энд эхлээд багшийн хүрэлцээний талаар л эргээд ярья. Тэгээд 8 сард 4200 багш дутагдалтай байна гээд тэгээд 10 сарын 1-нд мянга хэдэн 100 багш дутагдалтай байна гээд сайд зарлаж байсан. Тэгээд энийг энэ хоорондын нөхөлт хир явж байна. Одоо яг багш маань 100 хувь хангагдаж чадаж байна уу? Миний хийж байгаа судалгаагаар бүүр 20, 30, 40 хувь ч гэсэн ингээд багш нь дутагдалтай тэгээд ингээд байж байгаа хөдөө орон нутгийн сургуулиуд нэлээн тооцоо гарч ирж байгаа. Яг нэг мэргэжлийн багш нараар ингээд хангах тал дээр зүгээр л оронд нь нэг багш зааж байна тиймээ технологийн багш физик зааж байхад тэрийг физик зааж байна гэж үзэж явж байна уу гэдэг нэг чанарын энэ асуудлуудыг. Тэгэхээр багш дутагдлын асуудал яг өнөөдөр ямар болоод байна гэдгийг нь 8 сарын сүүл 10 сартай нь ингээд харьцуулаад асууя.

Тэгээд ер нь бол бид нар ингээд тэтгэвэрт гарсан хүнийг ажиллуулна ч гэдэг юм уу эсвэл төгсөх курсийн оюутныг ажиллуулна. Мэргэжлийн бус хүнийг хөрвөх хөрвүүлж ажиллуулна энэ тэр гэх аргаасаа илүү бид нар яг үнэхээр багш мэргэжлээр элсэх хүмүүсийг өнөө өглөөхөн бид нар ажлын хэсэг дээр бас МУБИС-ийн ректор энэ тэр гээд хүмүүсийг авчирч бас асуусан. Тэгээд шилдэг төгсөгчийг багш мэргэжил шилдэг гэдэгт нь би нэг 600-аас дээш авсан, 700-аас дээш авсан ЭЕШ-д ийм авсан оюутнуудыг ирээдүйд багш болгох талаар та бүхэн ямар ажил хийж байна ямар чиглүүлгүүдийг өгч байна гэдгийг нэг асууя.

Хөтөлбөр гаргаж байгаа. Итгэл захирлаас бас асуухад тэгээд энэ хөтөлбөрийнхөө хэрэгжилт хүртэл явах процессыг юу гэж харж байна? Энэ хэзээ ингээд нэг хүмүүс гаргаад ирлээ хөтөлбөр. Тэгээд энийг чинь энэ мэргэжлийн хүмүүсээр газар дээр нь ажиллаж байгаа багш нараас бас санал асуулга хэлэлцүүлгүүдийг яаж хийж байна? Тэгээд сурах бичиг хүртэл явах процессыг бас хийгээд цахим гээд хэт явах цахим сурах бичгүүд сайжирсныг энэ дээр сая харлаа. Тэгээд сайн сурах бичгүүдийг гаргаад сонголт хийлгээд тэрнээс нь өрсөлдүүлээд ингээд авах тал дээр багшийн сурах бичиг гаргаад багшийнх нь сурах бичиг нь нөгөө сурагчийнхаа сурах бичигтэй яаж дүйцэх вэ? Тэгээд бас онлайн оффлайн гээд сурах бичгүүд байдаг. Бас нэг асуух юм нь англи хэлийг бид нар 3 дугаар ангиас энэ жил 100 сургууль дээр үзэж байгаа гээд зааж байгаа гэсэн. Энд багш нараа яаж бэлдэж хангав аа? Дунд ангид нь үздэгийг нь аваад заалгачхав уу? Ер нь бага ангид бас онцлогтой шүү дээ. Заана гэхэд 3 дугаар ангиас үзэж байгаа хүүхдүүдэд зориулсан багш нараа англи хэлний багш нараа яаж бэлдэв гэдгийг асууя.

Дараа нь 2026 оны төсөв байна. Энэ төсвийг бүгдээрээ их хамтдаа хийх хэрэгтэй байна.

**Ч.Ундрэм:** Галбадрах гишүүнд нэг минут нэмчихье.

**Ж.Галбадрах:** Төсвийн асуудал бол их явдалтай юм байна шүү. Тэгэхээр эхнээсээ аягүй сайн гаргаж өгч энэ асуудлаа Сангийн яамтайгаа ингээд ярих үедээ гишүүд дотроо энэ лобби групп гаргаад яг энэ хэрэгцээ шаардлагыг нь гаргаад би одоо бас боловсролын ажлын хэсэг ерөнхий хуулийн хэрэгжилтийн ажлын хэсгийг ахалж байгаа хүний хувьд бол янз бүрийн тооцоонууд хийгээд хэчнээн бүр мега төслийн хэмжээнд ч хэрэгтэй гэсэн юм ингээд яриад явж байгаа. Тэгээд бүгдээрээ ингээд орох тал дээр ирэх жилийнхээ юман дээр их анхааръя аа. Энэ жил одоо өдрийн хоолны мөнгө хүртэл ингээд хасагдаж орж ирж байсан юм байгаа. Тэгээд суралцагчдын энэ эрх зөрчигдөж байгаа 40-өөс дээш хүүхэдтэй 2 мянгаас давчихсан сургуулиуд зөндөө олон байгаад байдаг. Энэ талын судалгаанууд яаж хийж байна? Энийг ойрын үед яаж арилгая гэж бодож байна? Ирэх жил PISA өгнө өө. Энэ Боловсролын үнэлгээний төв маань энэ шинэ захиралтай болсон юм шиг байна. Энэний бэлтгэлийг яаж хангаж байгаа вэ гэдэг талаар мэдээллүүдэд хариулт авъя.

**Ч.Ундрэм:** Эхлээд Наранбаяр сайд.

**П.Наранбаяр:** Галбадрах гишүүний асуултад хариулъя. Нэлээн бас том агуулгатай асуултауд байна. Тэгэхээр цаг жоохон яаж магадгүй. Аль болохоор товчхон хариулъя. Багшийн хүрэлцээ муу хомсдол байгаа нь бодитой үнэн шүү дээ. Бодитой үнэн. 4 мянга гарчихсан байсан одоо яг сая бид тоо аваад 11 дүгээр сарын дундуур харахад 986 болсон байна. Гэхдээ энд нэг айхтар бас тоо байна. Энэ нь юу вэ гэхээрээ улсын хэмжээнд мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан сургууль ердөө хорин хоёрхон хувьтай. Бусад нь хөрвөх аргаар ч юм уу далд хомсдол гэж ярьдаг. Ижлэвтэр төрлийн хичээл заадаг багш нь ухаандаа өөр төрлийн хичээлээ заагаад явчихдаг ийм нөхцөл байдалтай байна.

Тэгэхээр мэргэжлийн багш нараар хангагдах нь улсын хэмжээнд ердөө 22 хувьтай л байна. Ийм л байна. багш мэргэжлээр ажиллахаар багшаар суралцах энэ оюутнуудыг дэмжих үйл ажиллагаа тууштай явж байна аа. Боловсролын зээлийн сангаар багшаар суралцахаар төрийн өмчийн их дээд сургуульд бол бүрэн тэтгэлгийг нь олгоод явж байна аа. 2026 оны төсвийг хэлэлцэх үеэр үнэхээрийн таны хэлдэг үнэн. Их тийм тэвдүү төсөв орж ирсэн. Тодотгоод ингээд дараа нь төсөв ингээд хэдийгээр 9 сарын 1-нд тавьж олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн боловч бас яг тэнд мэргэжлийн байгууллагууд, холбоодууд, эрх ашиг нь хөндөгдөж байгаа хүмүүс бол дуу хоолойгоо тэр болгон хүргэж чадаагүй. Манай дээр Боловсролын яаман дээр хамгийн их санал ирсэн. 70 гаруй мянган санал. Үүнээс бол багш бүрд компьютер, хүүхэд бүрд компьютер гэдгийг хүссэн ийм хүсэлт нь бол энэний бараг 95 хувь нь байсан ийм л байдалтай байсан.

Тэгэхээр ерөөсөө энэ ирэх 2026 оны төсвийг хийхээсээ өмнө төсөв чинь энэ он гараад ингээд л хавар болоод л яригдаад эхэлнэ. Тэр үеэрээ бас Улсын Их Хурлынхаа энэ Байнгын хорооныхоо гишүүдийг уриад яаман дээрээ бас ярилцаад төсвийн анхны төслийг Сангийн яам руу хүргүүлэхээс өмнө та бүхэнтэй санал солилцъё. Энэ ер нь бол 40-өөс дээш хүүхдийн дүүргэлттэй бүлэг эд нар гээд

бидэнд тооцоо юу нь бол байдаг. Энэ Улаанбаатар хотод бол 40-өөс дээш дүүргэлттэй байна гэхэд нийтдээ 4872 улсын хэмжээнд 4872 ийм бүлэг байна.

Тэгэхээр энэ 40-өөс дээш дүүргэлттэй байна л гэдэг чинь чанартай сургалт явахгүй л гэсэн үг. Нэг ээлжийн сургууль руу ороогүй нөхцөлд бол бид нар хүн бий болгох ийм эсвэл авьяас чадлыг нь хөгжүүлэх сургалтыг ярихад нэлээн бэрхшээлтэй болно л гэсэн үг. Хүүхдийн эрх хөндөгдөж байна л гэж үзэх ёстой. Тэгэхээр цаашдаа бас энэ таны яриад байгаа мега төслийн хэмжээнд энэ боловсролын төслүүд сургууль цэцэрлэгийн хүртээмжийн асуудлыг ярих нь зүйтэй гэж бодож байгаа. Бидэнтэй хамгийн энэ чиглэлээр бас идэвхтэй ярилцаж санал солилцож дэмжиж яваа олон улсын байгууллагууд ялангуяа Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг энэ байгууллагууд бол бидэнтэй хамтраад хөнгөлөлттэй зээл олгох ийм бас боломжуудыг судалж байгаа. Энэ бол нэлээн урагштай явж байгаа гэдгийг дуулгая. Бид одоо энэ сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, яг боловсролын салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд бололцоотой бүхий л арга хэмжээг авах ёстой гэж бодож байгаа. Энэ дээр бас нэмж хэлэхэд энэ нэг хувийн татварын асуудал бол үнэхээрийн ААН-ийн нэг хувийн татварыг боловсролын салбарт хөрөнгө оруулсан тохиолдолд хөнгөлөх энэ асуудал эхэлж байгаа. Бид нийтлэг шаардлагыг нь гаргаад батлаад гаргачихсан. Ирэх 7 хоногийн Засгийн газрын хуралдаанд бол энэ олон яамдын нийтлэг шаардлагууд нийлээд нэг тусгай журам болж ингэж гарахаар яригдаж байгаа. Энэ бол бас энэ боловсролын салбарт ААН-ийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж байгаа ихээхэн дэвшилттэй ийм арга хэмжээ гэж бодож байна.

PISA -ын ийм талаар бол манай үнэлгээний төвөөс ярьчихна биз.

Ингээд үлдсэн асуултуудыг манайхан хуваагаад хариулъя аа. Баярлалаа.

**Ч.Ундрам:** Гантуяа дарга PISA үнэлгээний талаар.

**Г.Гантуяа:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. PISA 2025-ын бэлтгэл ажил бол өнгөрсөн 8 сараас эхлэгдээд явчихсан байгаа. Одоо бол бид нар бүх агуулгуудаа монгол хэл рүү орчуулаад хөрвүүлчихсэн. Нэг сар гэхэд бид нар сургуулийнхаа түүврийг эцэслэнэ. Тэгээд зохион байгуулалт хийх сургалтуудаа хийнэ. 2 сард бид нар компьютерын бэлэн байдлыг хангана. Тэгээд сурагчийн түүврээ эцэслээд ингээд 3 сарын 5-аас 5 сарын 16 хүртэл бид нар судалгаагаа үндэсний хэмжээнд авна. Нийт 200 орчим сургуулиас авна. Энэ бол 15 настай хүүхдийн сурч мэдсэн зүйлийг амьдралдаа хэрхэн ашиглаж байгаа гэдэг мэдлэгийг бид нар үнэлж шалгаж байгаа шалгалт байгаа юм аа. Нийт бид нар 61515 настай хүүхдүүдээс 7 мянган хүүхдийг авна. Газар зүйн байршил, сургуулийн байршил, өмчийн хэлбэр, боловсролын чиглэл, сургуулийн хэв шинжээс хамаарч түүврийн аргаар, программын аргаар сонгоно. Ер нь өмнө нь гарч байсан бэрхшээлүүдийг харахад бол ер нь хүүхдүүд маань одоо энэ судалгаанд оролцож байгаа хүмүүс маань өгөгдлөө ер нь бүрэн гүйцэд уншаагүй.

2.Урьд нь энэ смуляц буюу интерактив тестүүдийг асуулгуудыг хариулж чадаагүй. Даалгаврынхаа формат нь ер нь бол нэг гаднын формат учраас бас танил бус байсан. Өмнөх бэрхшээлүүд. Даалгаврын орчуулгатай үүдэлтэй бас бэрхшээлүүд байж байсан. Тухайн даалгаврыг олон улсынхаа түвшинд бас асуудалтай даалгаврууд гэж бас орж ирж байсан. Асуултаа бас бүрэн ойлгоогүй гэдэг асуудал гарч байгаа. PISA маань өөрөө яг бүх асуулгад орж байгаа хүмүүсийн

компьютерын суурь хэрэглээ маш чухал. Тэгэхээр компьютерын мэдлэг чадвар дутмаг байгаагаасаа яг энэ судалгаандаа бүрэн хариулж чадаагүй гэдэг асуудал гарч байгаа. Тэгэхээр бид нар бол Боловсролын Ерөнхий газар болон орон нутгийн болон нийслэлийн газруудтайгаа хамтраад энэ компьютерын бэлэн байдал болон энэ судалгаанд орох гэж байгаа хүүхдүүдийн ингэж танин мэдэхүйн PISA -г хэрхэн өгөх вэ гэдэг танин мэдэхүйн мэдлэг олгосон сургалт болон контентуудаар хүргэнэ гэж төлөвлөж байна.

**Ч.Ундрам:** Энэ PISA шалгалт бол маш олон улсад туршигдсан шалгалт боловсруулах өндөр чадвартай хүмүүсийн боловсруулаад олон улсад ингээд явуулж байгаа зохион байгуулж байгаа шалгалт шүү дээ. Тэгээд энүүгээр энэ шалгалтын өмнөх дүн бол ерөөсөө манай өнөөгийн боловсролын чанарыг шууд харуулсан байхгүй юу. Хүүхдүүд юм уншаад уншсан агуулгаа ойлгодоггүй, тоо энгийн аргын тоо бодож чадахгүй ийм л асуудал. Тэгээд хот хөдөөгийн ялгаа, төрийн сургууль, хувийн сургуулийн ялгаа гээд энэ дээр тов тодорхой гарсан.

Тэгэхээр энэ жил ирэх жил зохион байгуулахдаа өмнөх үр дүнгүүдтэйгээ харьцуулаад бид нарт дэвшил гарч байна уу үгүй юу тэр бол харагдах бүрэн боломжтой болж байна гэж ойлгож байгаа. Энэ дээр нэмээд Наранбаяр сайд.

**П.Наранбаяр:** Баярлалаа энэ энэ жилийн PISA-ийн нэг онцлог нь бас байна аа. Тэр нь юу вэ гэхээрээ чанарын судалгаа орж ирж байгаа. Ерөөсөө эцэг эх багш тэгээд сурагч хүүхдүүдээс ийм анкет судалгаа авна гэсэн үг. Энэ орж ирж байгаа.

Дээр нь цахим ур чадварыг нэлээн асуух ийм зүйлүүд нэмэгдэж орж ирж байна лээ. Тэгэхээр энэ чиглэл рүү нь бас бид эртнээс бэлтгэлээ хангахаар яригдаж байгаа, ярьж байгаа. Тэгэхгүй бол яг энэ чанарын үнэлгээ дээрээ ихээхэн унадаг. Та бүхэн мэдэж байгаа бол төвийн бизнес ч юм уу бизнесийн орчныг үнэлдэг дэлхийн банкны тэр үнэлгээ рүү манайх яагаад дандаа хойгуур ороод байдаг гэхээр бас тэр чанарын үнэлгээ дээрээ хариулж байгаа хариулт нь янз бүр болоод бас тэр чиглэлээр бас дас дасаж дадаагүй байсан ийм юм их нөлөөлдөг. Яг ийм нөлөөлөл гарах вий гэсэн болгоомжлол байна. Энэ чиглэл рүү бас их сайн бэлдэх ёстой гэж бодож байгаа. Ер нь PISA-ийн шалгалт бол манайх эхний удаад яасан гэхэд маш сайн зохион байгуулсан гэж үнэлэгддэг юм байна лээ. Энэ жил энэ удаа ч гэсэн бид нар зохион байгуулалт.

**Ч.Ундрам:** Англи хэл сурах бичгийн талаар бас асуусан. Итгэл дарга хариулах уу? 3 номер. 2 номер юм байна.

**М.Итгэл:** Та бүхэнд энэ өдрийн амгаланг айлтгая.

Эхлээд сургалтын хөтөлбөртэй холбоотой би товч мэдээллийг өгье.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр менежментийн цикл гэдэг энэ зүйл дээр явж байгаа. Өөрөөр хэлбэл 10-аас 12 жил тутамд бол шинэчлэгдэнэ гэдэг ийм концепцтой. Энэний дагуу 2024 оны Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны 6 сарын 26-ны тушаал гараад СӨБ болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх тохирцыг шалгах гэсэн ийм хэрэгжүүлэх тушаал гарсан. Энэ дээр өөрөөр хэлбэл 2024 онд бол СӨБ баг 2025, 2026 онд болон харгалзан суурь болон ахлах сургалтын хөтөлбөрийг боловсруулж турших гэдэг ийм концепцтой явж байна. Яг тэрний дараа жил бол хэрэгжүүлэх гэдэг



ийм төлөвлөгөөтэй явж байна аа. Яг өнөөдрийн байдлаар бол 18 цэцэрлэг, 27 сургууль дээр бага боловсролын туршилт бол явагдаж байна. Өөрөөр хэлбэл 7 мянга орчим сурагч дээр бол энэ бол төвлөрөөд явагдаж байна аа. Товчхондоо бол тохирц найдварыг шалгах ийм зүйл явагдаж байна.

Шинэлэг зүйл гэвэл сурах бичгийг сая бас ярьсан дасгал ажлын дэвтэр, сурах бичиг гэсэн ийм 2 үзүүлэлттэй болсон учраас эхний бид нар бол мэдээлэл цуглуулалтаар цүнхний юу бол багасах юм байна жин багасах юм байна.

Хоёрдугаарт нь гэрийн даалгаврыг бол яг тогтвортой яг нэгэн жигд өгөх өөрөөр хэлбэл хүүхэд болгонд тохирсон байдлаар өгөх ийм боломжтой байна гэдэг ийм мэдээлэл бол цуглаад ирсэн байж байна. Мөн багш нар дээр бол суралцахуйн удирдамж, багшийн ном гэдэг ийм 2 зүйл явдаг байсан бол энийг нэгтгээд ерөөсөө шууд сурах бичиг, дасгал ажлын дэвтэр, сургалтын хөтөлбөрийг бол холбосон ийм багшийн ном байхаар бол төлөвлөөд бид нар энийгээ бас хийгээд явж байна аа. Англи хэлний хувьд 100 сургууль дээр бол туршилт явагдаж байна. Энэ дээр бид нар багш нарын санал дээр үндэслээд бол энэ туршилт явагдаж байна. Өөрөөр хэлбэл англи хэлний багш заах боломж тухайн бага ангийнх нь багш заах боломж гээд энэ дээр үндэслээд туршилт бол яг процессын чанартай явагдаж байна.

**Ч.Ундрам:** Багш нар нь бэлэн юм уу гэж асуусан. Англи хэл заах багш нар. Итгэл даргын микрофоныг өгөөрэй. 2 номер.

**М.Итгэл:** Энэ 100 сургуулийн хувьд бол бид нар яг нөгөө яг бэлэн байгаа юун дээр туршилтад бэлэн байгаа багш нарынхаа хүрээнд бол бид нар энд 100 сургуулиа сонгож явж байгаа. Цаашдаа бид нар бол яг багш нарынх нь хувьд бэлтгэл ажлыг хангах гэдэг чиглэл дээр явж байгаа юм.

**Ч.Ундрам:** Багш нараа бэлдэж байгаа гэсэн үг юм уу? Цаашид бүх сургууль руу нэвтрүүлэхэд багш нар чинь бэлтгэгдээд явж байгаа юм уу? Яг багш нарын. 1 номерын микрофоныг өгчихье. Яг тодорхой асууж байна шүү дээ, тодорхой хариулаад өгөөч.

**П.Оюунаа:** Тэгэхээр одоо бид нар 3, 4 дүгээр ангиас эхлээд англи хэлийг оруулж ирсэн. Хөтөлбөрөө бас нэлээн багш нарынхаа ур чадварын түвшинд нийцүүлээд 1 дүгээрт, 2 дугаарт нөгөө цахимын платформ дээр байгаа агуулгууд нь багшийн ур чадварыг жоохон нөхөх байдлаар эхний байдлаар ингэж бэлтгэсэн юм. Тэгээд одоо бид нар яг хэн заах вэ гэдэг дээр нэлээн бас хэлэлцүүлэг 100 сургуулиудынхаа түвшинд өрнүүлээд ер нь 3 хувилбараар яваад үзье гэж ярьж байгаа.

Тэртээ тэргүй бид нар англи хэлний багш нар бол бас сургуулиудад хангалттай байхгүй байгаа. Тэгээд ер нь бол англи хэлийг бас заагаад нэмэлт байдлаар би эхний үед туршаад яваад үзье гэсэн сонирхолтой бага ангийн нэг хэсэг багш нар байгаа. Дунд ангиасаа доошоо зааж байгаа нэг хэсэг байгаа. Тэгээд мөн дадлагажуулагч англи хэлний багш нар бас байгаа. Тэгэхээр үндсэндээ бид нар 3 хувилбар дээр явж байгаа. Тэгээд ингээд туршилтын үр дүн дээр бид нар 3, 4 дүгээр ангид англи хэл.

**Ч.Ундрам:** Нэмэлт нэг минут нэг номерт өгье.

**П.Оюунаа:** Одоо туршилтын төгсгөлд бид нар яг багшийг яаж бэлтгэх вэ, нэмж сургах вэ? Энэ тохиолдолд бид нар энэ зохицуулалтыг яаж оруулах вэ гэдгийг туршилтын үр дүн дээр гарна. Одоогоор бол бид нар эхний байдлаар хараахан үр дүнг аваагүй байгаа. Тэгэхээр ер нь энэ 3 хувилбарын л нэг явна эсвэл 2 хувилбар нь явж таарна. Тэгэхээр одоогийн байдлаар бол бид нар яг дандаа бага ангийн багш нар заана эсвэл дандаа дунд ангийн англи хэлний багш нар доошоогоо заана гэсэн ийм үр дүн хараахан гараагүй байна.

**Ч.Ундрам:** Нэг статистик тоо мэдээ байна уу? Яг англи хэлний хэдэн багш байна? Тэгээд саяын энэ хувилбарууд дээр чинь хэд хэд нь бэлэн байна гэсэн тийм тоо бэлэн байна уу?

**П.Оюунаа:** Одоо нөгөө яг бага ангийн багш нар нь хэрвээ заавал яаж явах вэ гэдэг хувилбарууд маань эцэслэгдэж гараагүй учраас бага ангийн нийт багшийн хэдийг нь бид нар англи хэлний багшаар нэмж сургах вэ гэдэг тоонууд хараахан гараагүй. Ерөнхий боловсролын 6-аас 12 дугаар англи хэлний нэг 5 мянга орчим багш байгаа. Тэгэхдээ бас дутагдалтай байгаа бид нар дээр. Тэгэхээр энэ багш нараасаа сургууль болгон дээр нь харилцан адилгүй байгаа.

Тэгэхээр нөгөө бүлгийн тооноос шалтгаалаад зарим англи хэлний багш нар бол хангалттай хичээлийн цагтай. Зарим нь бол 19 цаг нь ч хүрэхгүй тийм англи хэлний багштай сургуулиуд ч бас байгаа. Тэгэхээр эд нар дээрээ бид нар зохицуулалт л хийж таарна. Гэхдээ туршилтынхаа үр дүнг харж байж зохицуулалт хийхгүй бол одоо бол бид нар үр дүнг иймэрхүү байдлаар цаашдаа үндэсний хэмжээнд явна гэж хэлэхэд арай эрт байна.

**Ч.Ундрам:** Галбадрах гишүүн нэмж асуулт нэг минут.

**Ж.Галбадрах:** Тийм бүгдээрэнд дахиад нэмээд асуумаар байна л даа. Тэгэхдээ саяын англи хэл дээр асуумаар байна? Үнэхээр энэ хүүхдүүдийг бэлтгэл хангахад Япон бас яг 3 дугаар ангиас үзэхдээ гадаад багш заавал нэг сургуульд нэг байна ч гэдэг юм уу тэрийг багшаа бэлдэж байгаад ингээд орсон байна. Тэгэхээр манайд бол дунд сургуулийн багш ингээд бага ангид орохоор нөгөө үсгээ яаж заадаг билээ? Хүүхэд дээрээ зөрөлдөөн гараад байна. Бага ангийн багш нар маань англи хэлтэй байна уу гэвэл бас байхгүй шүү дээ. Сая МУБИС бол өөрөө бага ангийн багшийг англи хэлтэй бэлдэж байгаа л гэж байна лээ. Тэр энэ тэр гараад ирвэл бас болохоор байна. Таны ярьж байгаа шиг. Тэгэхээр энэ бэлтгэлүүдийг ингээд сайн хийж байж орохгүй бол одоо 3 дугаар ангийн хүүхэд чинь бол youtube-ээр дээр Англи хэлийг өөрсдөө ингээд үзэж байгаад сурчхаад байгаа тийм чадвартай хүүхдүүд байгаад байгаа шүү дээ. Тэрэн дээр багш орж ирээд тэр юуг нь зогсоогоод ингээд байх вий тэрийгээ хэдүүлээ нэг сайн харах хэрэгтэй.

Нөгөө талаас үнэлгээний төв дээр сая зүгээр шалгалт зохион байгуулах тухай юмаа яриад байна. Одоо энэ 4 сар өнгөрчихсөн байна шүү. Өнгөрсөн шалгалтын дүн дээрээ анализ хийгээд сургууль... /минут дуусав/.

**Ч.Ундрам:** Алтаншагай гишүүн асуулт асууя. Сая үг хэллээ гэж ойлголоо.

**Н.Алтаншагай:** Өдрийн мэнд хүргэе баярлалаа. Танилцуулга хийе. Тэгээд тодруулах хэдэн зүйлүүд байна. Асуулт юм даа. СӨБ-ын байгууллагын энэ ажилчин, албан хаагч сургууль цэцэрлэгийн ерөнхийдөө захирал, эрхлэгч дээр нь багш гээд

үндсэн орон тоо байгаа. Шинэ хууль хэрэгжсэнээрээ нөгөө цахилгаанчин, туслах тогооч, аяга угаагч гээд ийм туслах боловсролын байгууллагад байгаа захиргааны ар талын алба бас хүнд байдалд орсон гэсэн ийм саналуудыг сургууль, цэцэрлэгийнхэн ихээр хэлж байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэг яг бодит хариу өгөөч. Буцаад орон тоогоо нэмж авъя л гэж байгаа юм сургууль. цэцэрлэгийнхэн маань.

Томилгоотой холбоотой асуудал. Энэ хуулийн өмнө аймаг дүүрэг нь өөрөө томилгоог хийдэг байсан. Энэ хууль хэрэгжсэнтэй холбоотойгоор буцаад Боловсролын яам руу газар руугаа явчихсан. Тэгээд орон нутагтайгаа нөгөө боловсролын байгууллага нь ойлголцож хамтарч ажиллахад тэгээд асуудлууд яг бодит хөрсөн дээрээ үүсэж байгаа юм. Энэ дээр нэг яаж шинэчлэх юм цаашдаа энэ маань яг ямар хэлбэр рүү шилжиж явах юм бэ гэж. Орон нутгийн нэмэгдэл гээд одоо бас яригддаг. Энэ бол хөдөө орон нутагт байгаа 5 жил, 3 жилээр ингээд ажилласан багш нар 6 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг аваад явж байгаа.

Улаанбаатар хотод энэ өөрөө яг тулгамдсан асуудлуудын нэг мөн шүү дээ. Нэг ангид 40, 50, 60 хүүхэдтэй ангид хичээл зааж байгаа багш нар байна. Тэгэхээр энэ нэмэгдлийг орон нутаг гэж ялгалгүй шийдвэрлэх асуудал дээр онцгойлон шийдвэр гаргаач гэж 1 дүгээрт үзэж байгаа юм.

Хоёрдугаарт Улаанбаатар хотыг тойрсон энэ алслагдсан хороодуудын сургуулиудад энэ нэмэгдэл олгож байгаа. 5, 3 жилийн нэмэгдэл олгож байгаа. Энийг энэ төвийн яг ачаалалтай байгаа энэ Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй гээд энэ төвлөрсөн сургуулиуд дээрээ ерөнхий боловсролын сургуулиуд дээрээ энийгээ энэ багш нартаа олгооч гэсэн энэ хэрэгжилт явах боломжтой юу гэж. Их дээд сургуулиуд дээр бас тодорхой энэ ёс зүйн асуудалтай холбоотой олон гомдлууд ирдэг. Тэр бол яг тэр тухайн их дээд сургуулиудын дотоод асуудал байх. Нэгхэн хичээлийн шалгалтаас болоод 3, 4 жил ингээд төгсгөөгүй сургууль байна шүү дээ оюутнаа ганцхан хичээлээр нь бариад. Тэр эрхлэгчтэйгээ үл ойлголцсоноос болоод ингээд 4 жил төгсгөөгүй. Энэ чиглэлээр надад гомдол ирсэн байгаа. Би энийг холбогдох дагуу яаманд бас сайдад нь хүргүүлъя. Энэ СУИС-ийн харьяа сургууль.

**Ч.Ундрэм:** Нэмэлт минут авах уу Алтаншагай гишүүн. Нэг минут нэмж өгье.

**Н.Алтаншагай:** Энэ намайг дүүргийн Засаг дарга байхад л яригдаж байсан асуудал. 2 жил, 3 жил. Би өөрөө хүртэл хөөцөлдөөд тэгээд бараагүй сүүлдээ орхисон. Албан тоот өгөөд хүсэлт өгөхөөр яасан их танилтай юм гээд улам дарамтлаад ингээд шалгалт өгөхөөр хөөгөөд гарчихдаг. Ганцхан хичээл тэр гуравхан кредиттэй нэг хичээл байгаа байхгүй юу. Тэгээд тэр өөрөө эмэгтэй айлын ганц хүүхэд. Тэгээд маш их хүнд байдалд орсон гэр бүлээрээ. Тэгээд 4 жил ингээд сургуулиа төгсөж чадаагүй. Сурлагын түвшин нь боломжийг сайн хүүхэд байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр би одоо бас араас нь явж холбогдох газар нь хандъя гэсэн ийм бас хүсэлтийг салбарын сайдад нь хүргүүлъя болсон.

**Ч.Ундрэм:** Наранбаяр сайд хариулъя.

**П.Наранбаяр:** Алтаншагай гишүүнд баярлалаа. Тэгэхээр СӨБ-ын буюу сургууль цэцэрлэгийн орон тоон дотор аяга угаагч, харуул, цэвэрлэгч гэх мэт үйлчилгээний албанд нь аж ажилладаг улсуудын орон тоо хэтэрхий цөөн байна нэмэх хэрэгтэй байна гэсэн дуу хоолой бид ч гэсэн цэцэрлэгийн эрхлэгч нартай

цэцэрлэгийн ажилтнуудтай уулзаж байхад ийм дуу хоолойг сонсож байсан. Ямар нэгэн байдлаар тэр жишиг орон тоо хасагдаагүй ээ.

Бид одоо Сангийн яамтай хамтраад, Сангийн сайдтай хамтраад жишиг орон тоог баталж ингэж явдаг. Энэ дээрээ ч гэсэн энэ дуу хоолойг шингээгээд аваад явна. Ер нь цаашдаа ийм үйлчилгээний ажлыг өнөөдөр та бүхэн мэдэж байгаа. Төрийн албан хаагчдын тоо 226 мянгаасаа даваад 230, 240 гээд ингээд их их болж байгаа. Энэ нөхцөлд бас ийм яг ийм үйлчилгээний алба эрхэлдэг улсуудыг хувийн хэвшилд шилжүүлэх тэгэхдээ хөдөлмөрийн нөхцөлийг нь дордуулахгүйгээр ажлын байрных нь баталгааг хангах замаар ингэж шилжүүлэх гэсэн ийм ер нь ерөнхий бодлого бас явж байгаа.

Тэгэхээр цаашдаа бас шинээр баригдаж байгаа сургууль, цэцэрлэг дээр бол энэ үйлчилгээнийх нь албан хаагчдыг хувийн хэвслээр ингэж гэрээлэх замаар бусдаар гүйцэтгүүлэх энэ гэрээний хүрээнд ажил үйлчилгээний хүрээнд шийдвэрлэх ийм бодлого руу бас аажим аажмаар орж байгаа гэдгийг энэ завшааныг ашиглаад дурдах нь зүйтэй байх аа.

Томилгооны асуудлыг хөндлөө. Энэ яг Боловсролын ерөнхий хууль дээрээ заачихсан хуулийн заалттай зүйл. Их л олон жил савласан даа. Та ч бас мэдэж байгаа шүү дээ эхлээд ингээд шууд төвөөс нь юу төрийн захиргааны төв байгууллага шийдэж үзлээ. Одоо төрийн захиргааны байгууллага шийдэж байна. Ингээд орон нутаг нь шийдэхгүйгээр энэ босоо бүтцээрээ шийдээд явъя гэсэн ийм өөрчлөлт рүү сая хуулиар орчихсон. 2023 оны 7 сарын 7-ноос хойш. Юуны хувьд бол орон нутгийн бие даасан байдлыг нутгийн өөрөө удирдах ёс энэ бодлогыг байдлыг мөн Засаг даргын боловсрол, эрүүл мэнд гэсэн хүний амьдралд зайлшгүй хэрэгцээтэй үйлчилгээн дээр гүйцэтгэх үүргийг нь бодох юм бол бас уг нь таны хэлээд байгааг ойлгохгүй байх газар байхгүй.

Зарим тал дээрээ тийм хэт улс төржүүлсэн янз бүрийн тийм томилгоо явсан гэсэн ийм шүүмжлэл байдаг юм байна лээ. Энэ аяндаа бас энэ систем өөрөө сайн ажиллахгүй байна гэдэг нь харагдах юм бол аяндаа дахиад өөрчилж болох байх гэж бодож байна.

Орон нутгийн нэмэгдлийн асуудлыг Улаанбаатарт ч гэсэн олговол ямар вэ? 5 жил, 3 жил тийм ийм. Яагаад сумандаа очоод өөрөө ингээд багшлаад эхлэх юм бол үндсэн цалин дээр нь 40 хувийн нэмэгдэл өгч байгаа. Энэ бодлого нь өөрөө төвлөрлийг сааруулах хамгийн мэргэжлийн багш нар хэрэгтэй байгаа орон нутагт багшлах боловсон хүчнийг олноор нь суурьшуулах тэнд байршуулах ийм зорилготой явж байгаа бодлого. Ийм учраас нөгөө төвийн дүүргүүд дээр энэ бодлогыг хэрэгжүүлэх бас боломж их хомс байгаа гэдгийг танд тайлбарлая. Гэхдээ анги даасан багшийнх нь нэмэгдэл ч юм уу энэ хүүхдийн ачааллыг тооцсон нэмэгдлийг бас байлгаж энэ дээр бас бодлого боловсруулах бас боломжтой юм болов уу гэж харж байна.

Тэр их дээд сургуулийн тэр 4 жил төгсөж чадаагүй нэг тохиолдлыг та ярьж байна. СУИС дээр байгаа юм байна. Үнэхээрийн хуулийнхаа дагууд дүрмийнхээ дагууд хийсэн юм уу үгүй юм уу гэдгийг судалж үзье. Та тэр хүний материалыг нааш нь ирүүлээрэй. Бид бас хуулийнхаа хүрээнд л ярилцъя. Тэгэхдээ аливаа их дээд сургуулийн үйл ажиллагааг бол хуулиар нь академик эрх чөлөө бие даасан байдлыг нь хангаад удирдах зөвлөл дээр нь бүх эрх мэдлийг нь өгчихсөн тэд өөрсдөө бие

даан ийм шийдвэр гаргаж байгаа ийм нөхцөлд бид яах вэ мэргэжлийн хүрээнд судалж үзээд тэгээд зөвлөмж маягаар ингэх ёстой юм биш үү гэсэн ийм саналаа бас өгч болно гэдгийг хэлье. Баярлалаа.

**Ч.Ундрэм:** Хариулт хангалттай юу Алтаншагай гишүүн? Тодруулъя нэг минут.

**Н.Алтаншагай:** Энэ томилгоотой холбоотой дахиад нэг асуудал байгаа юм. Менежер арга зүйчээр ажилласан хүнийг цаашдаа томилно гэсэн нэг ийм заалт хэзээ орж ирсэн юм. Үүнээс болоод тэгш байдал бас алдагдаж байгаа байхгүй юу. Нөгөө арга зүйчээр ажилласан хүнийг сургууль нөгөө цэцэрлэгийн эрхлэгчээр менежерээр ажилласан хүнийг томилно гэгчихсэн ийм заалттай 8 жил байх аа. Тэр нь их өндөр заалттай тэгээд арга зүйч нь нөгөө үндсэн багшаасаа бага цалинтай байдаг. Тэгээд энд яг бас сургууль, цэцэрлэг болгон дээр л яригдаж байгаа асуудал.

Дараачийнх нь энэ Улаанбаатар хотын энэ захын энэ гэр хороололд байгаа цэцэрлэгүүд маань туслах багшгүй болсон шүү. Туслах багшийн энэ асуудал дээр бас нөгөө сургалт курс байдаг. 14 хоног суугаад үнэмлэх аваад очдог.

**Ч.Ундрэм:** Хэн хариулах вэ? Наранбаяр сайд.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Тэгэхээр энэ менежер арга зүйч гээд энэ ийм юмаар ажилласан байх шаардлага дүүргийн болоод одоо жишээлбэл Боловсролын газрын даргаар ингээд очиж ажиллахад заавал сургуулийн захирал тэдэн жил менежер, тэдэн жил хийх ёстой байх гэсэн ийм нэг хуулийн заалт бол Боловсролын ерөнхий хууль дээр ийм тусгай шаардлага болоод ороод ирчихсэн юм аа.

Тэгэхээр энэ бол мэргэжлийн удирдлага руу шилжүүлэх ийм зорилгыг л агуулсан ийм заалтууд. Тэгээд бас энэ боловсролын газрыг удирдаж чиглүүлж явахад өөрөө захирал хийж, өөрөө багшилж үзээгүй ийм хүн ажиллуулах нь тохиромжгүй байна. Энэ яг мэргэжлийн ийм удирдлага руу оруулъя гэсэн ийм л байдлаар шийдсэн. Тэгээд ялангуяа хөдөө орон нутагт очоод үзэхээр яг энэ шаардлагаа хангасан хүн бас их ховор олддоггүй. Тэгээд яг зарлахаар бас хүн ирж өгдөггүй ингээд ажлын байр нь байгаад байдаг нээлттэй сонгон шалгаруулалтын зарлагаар ирдэггүй ийм хүндрэл гарч байгааг бас энэ хэлэх нь зүйтэй байх аа.

**Ч.Ундрэм:** Энэ сургалтын менежер дээр нэмж асуухад багш нараасаа бага цалин багш нарын нөгөө илүү цаг гээд гүйцэтгэлийн үнэлгээ нэмэгдлүүдтэй харьцуулахаар хамаагүй бага цалин аваад байна аа. Гэтэл ачааллын хувьд бол маш олон, ялангуяа том сургуулиудын хувьд олон багш нарыг арга зүй мэргэжил арга зүйгээр хангадаг ийм ажлын байрны тодорхойлолтын хүрээнд ачаалалтай байдаг. Гэтэл бид нарын цалин ингээд хамаагүй бага байгаад байдаг. Тэгээд энэ дээр 8 жил ажиллаж байж захирал болно гээд тэгэхээр ер нь бол олон багш нар менежер болох сонирхолгүй болчихдог юм байна лээ. Цалин мөнгөө бодсон ч гэсэн. Тэгэхээр энэ дээр ямар бодлого ер нь барих ёстой юм бэ яамнаас. Та хэд юу гэж бодож дүгнэж байна? Наранбаяр сайд.

**П.Наранбаяр:** Энэ Ундрэм гишүүний хэлсэн энэ бол бодитой байдал үнэн. Юу вэ гэхээр яг энэ өөрөө ингээд менежер хийж байгаа ийм хүн ачаалал маш их байдаг. Нийгмийн ажилтан ч тэр ачаалал их, сэтгэл зүйч ч тэр. Гэвч багшаас ингээд доогуур цалин авч байгаа ийм тохиолдол байна. Боловсролын яг дүүргийн болоод

аймгийн боловсролын газарт ажиллаж байгаа мэргэжилтэн ч гэсэндээ цалин туйлын доогуур байгаа. Бүр ингээд байгаа шүү дээ аймгийн Боловсролын газарт ажиллаж байгаа яг энэ төрийн албан хаагч хүн биднийг ТҮ буюу төрийн үйлчилгээ болгоод өгөөч. Тэгэх юм бол илүү цалин авчих гээд байна гээд. Ийм л нөхцөл байдалтай байгаа.

Тэгэхээр ажлын байрыг нь зураглалыг нь хийж байгаад энэ асуудлыг бас цогцоор нь шийдэх шаардлагатай. Тэгэхгүй бол үнэхээрийн боловсролын удирдлага менежмент суларч эхэлж байгаа, хийх хүсэлтэй хүн байхгүй болж байгаа энэ үнэн. Та яг зөв зүйлийг дурдлаа. Баярлалаа.

**Ч.Ундрэм:** Тэгэхээр яамнаас энэ дээр ажлын байрны зураглал гаргаад ийм зөв хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх юм байна гэсэн ийм хүлээлт гарч байна аа. Бямбасүрэн гишүүн асуулт асууя.

**Ш.Бямбасүрэн:** Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Тэгээд танилцуулгатай танилцлаа. Тэгээд энэ танилцуулга дээр хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоог шат шатын боловсролын юунд нь харуулж байна л даа. Гол нь энэ чанар ямар байгаа вэ? Тэр багш нар нь бас хангалттай байгаа юу? Ер нь яг одоо манай улсад яг ийм хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан энэ чанартай багш нар ер нь хэд байхаас хэд байгаа вэ? Энэний бас тоогоо бас та бүхэн маань бас мэдэж байгаа юу гэдэг нэг эхний асуулт байна. Тэгээд орон нутгаар явж байхад энэ багшийн туслах бол ямар нэгэн урамшуулал тэтгэмж авдаггүй ээ. Бид нар бол ер нь багштайгаа л өглөөнөөс орой болтол яг ингээд хүүхдүүдтэйгээ цуг байдаг аа. Цэцэрлэг, бага ангийн энэ багшийн туслахууд гээд. Тийм гомдлуудыг бол маш их хэлж байсан. Тэгээд энэн дээр бас яг багшийн туслахуудад бас тийм урамшуулал тэтгэмжийн юм байгаа юу? Бас энэ яг багшийн хомсдолтой байгаа үед өнөөдөр бол багшийн туслахууд бас үүрэг их байгаа гэж харж байгаа. Тэгээд энийг бас нэг тодруулмаар байна.

Ер нь багшийн нэг багшийн ер нь ажиллах цагийн норм ер нь хэд байдаг юм бэ? Одоо манай Дорнод аймгийн Хэрлэн сумын нэг сургуульд 1800 хүүхэдтэй тэгээд биологийн багш ганцхан байдаг гээд 40, 50 цаг 7 хоногт багшилдаг гэж байгаа юм. Тэгээд үнэхээр бол 50 цагт нэг багш багшилдаг тэгээд бэлтгэх ямар ч боломж байхгүй. Тэгэхээр зэрэг чанарын асуудал ярьж байгаа юм.

Тэгэхээр ер нь орон нутагтаа ер нь манай энэ яам ер нь хэрхэн хамтарч ажиллаж байгаа юм бэ? Орон нутгийн удирдлагууд бас тодорхой хэмжээнд энэ асуудлаа шийдмээр байна гээд тус тусдаа тэнд бодлого гаргаад гаргах гээд ингээд төсөв мөнгө тавиад ингээд яваад байдаг. Тэгэхээр ер нь манай яам ер нь нэг сум аймаг энэ дүүрэгтээ ер нь хэрхэн яг энэ дээр ажиллаж байгаа вэ гэж асуумаар байна. Тэгээд энэ нэг боловсролын хуулийн энэ шинэчлэлээр миний ойлгосноор их дээд сургуулиудыг эрэмбэлэх, цаашлаад энэ ерөнхий боловсролын сургуулиудыг эрэмбэлэх энэ одоо дэлхийн топ сургууль гэж бид нар ярьдаг. Монголын топ сургуулиудаа бид нар ер нь хэзээнээс эхэлж эрэмбэлж эхлэх юм бэ? Энийг ер нь хийхгүй юм уу? Тэгэхгүй бол одоо ер нь ингээд энэ нэг дээд боловсролын энэ дипломын үнэ цэн гэдэг юм ер нь Монголд бол утгаа алдлаа шүү дээ. Ер нь Монголоор дүүрэн дипломтой худалдагч энэ үйлчлэгч нар бий боллоо гэдэг шүүмжлэлийг хэлж байна.

Тэгэхээр хэдүүлээ энэ аль сургуулиуд маань ер нь чанартай яг сургууль өгөөд байгаа юм? Тэрийгээ бид нар хэмжиж чадаж байгаа юм уу? Чадаж байгаа бол тэрийгээ бид нар хэзээнээс бид нар зарлах юм бэ гэдэг асуулт асууя.

**Ч.Ундрам:** Наранбаяр сайд хариулъя.

**П.Наранбаяр:** Энэ Бямбасүрэн гишүүний асуултад хариулъя. Энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд заадаг багш нарын тоо гэхэд СӨБ-д 3900 багш байна. Энэ ерөнхий боловсрол бол тэгш ороод ирэхээр тэгш хамран суралцах гэдэг утгаараа насан туршийн боловсрол болоод бусад багш нар нь хамтраад түүний зэрэгцээ мэргэшсэн багш нар нь ингээд хүүхдээ хүлээж аваад сургаад явдаг. Өнөөдрийн байдлаар 2024-2025 оны хичээлийн жилд тэгш хамран сургах мэргэжлээр суралцагчийн тоог ингээд танд харъя. Тэгэхээр танд хэлье. Тэгэхээр энэ Багшийн их сургуульд сурч байгаа 1 дүгээр курст нь 14 оюутан ингээд, 16, 12, 10 гээд ингээд цөөн тооны оюутан сурч байна. Магистрантад бол 12. Хөрвөх сургалтад нь 25 оюутан байна.

2016 оноос хойш бол тэгш хамран сургах боловсролын үндсэн хичээлийг 2701 оюутан судалсан байна аа. Энэ ихэвчлэн СӨБ болоод бага сургуульд заах багш нарыг бэлдэх хүрээнд ингэж үзэж байгаа. Тэгш хамран сургах боловсролын үндсийг цаашдаа бид энэ бүхий л багш мэргэжлээр сурч байгаа бүх хүн үзэх ёстой гэсэн ийм бодлогыг барьж байгаа гэдгийг хэлье. Тэгээд бас энэ багшийн та сургуулиудын эрэмбийн асуудлыг хөндөж байна. Тэгэхээрээ дээд боловсрол дээр бол энэ Дээд боловсролын хууль дээрээ заачихсан эрэмбэ чансааг заавал тогтоодог. Энүүгээрээ бол 2 жил тутам тогтоодог байгаа. Энд энэ жилийнх нь бол гарсан. Энэ эрэмбэ бол зөвхөн дээд боловсрол дээр явдаг. Дунд сургуулийн ерөнхий боловсролын сургуулиудыг бол хуулиар эрэмбэлдэггүй юм аа. Эрэмбэ бол ерөөсөө л чансаа чанарыг нь харах, чанарыг дээшлүүлэхэд ийм чиглэсэн ийм бодлого байдаг. Багшийн ачаалал бол цагийн норм нь 7 хоногтоо 19 цаг байдаг. Ингэж байж ээлжит хичээлдээ бэлддэг. Ингэж байж чанартай сургалт явдаг. Гэтэл та хэлж байна тэр Дорнод аймгийн 1 дүгээр сургуульд биологийн багш нь 50 цагтай байна гэдэг бол энэ ямар ч чанартай сургалт явуулах боломжгүй. Багшийн хомсдол гэдэг чинь, яг дутал гэдэг чинь яг ийм юман дээр яваад байгаа. Тэгэхээрээ энэ хүүхдийн эрх ч гэсэн зөрчигдөж байна л гэсэн үг. Багшийн хөдөлмөрлөх эрх ч зөрчигдөж байна 3 дахин илүү ачаалалтай явна гэдэг бол энэ эрүүл мэндээрээ хохироход ч гэсэн хүрнэ. Энэ аюултай зүйл бид анхааръя.

Багшийн туслах яг одоо ялангуяа СӨБ дээр багшийн туслахаар ажиллаад яг л адилхан ачаалалтай ажилладаг атлаа яг бусад багштай харьцуулахад нэмэгдлүүдээ тэр болгон авч чадахгүй байгаа нь бодитой үнэн. Энэ бол бас хууль дээрээ нэмэгдлүүдийг багш гээд заачихсан. Багшийн туслахыг бас энэний гадна орхисон ийм нэг тал бий. Бололцооны хэрээр боломжийнх нь хэрээр бас цалинг нь өсгөх орлогыг нь нэмэгдүүлэх бодлого барьж ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

**Ч.Ундрам:** Наранбаяр сайд энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын чанарыг нь асуугаад байна тиймээ? Чанар нь хэр явж байгаа гэж үзэж байгаа вэ гэсэн байна. Тэгээд орон нутагтаа хэрхэн ажиллаж байна вэ? Яам гэсэн асуулт байна. Тэгээд их сургуулиудын эрэмбийг энэ жил тогтоосон гэж байна. Тэрийг би ерөөсөө олж хараагүй. Тэр эхний топ 5-д нь аль аль их сургууль орчхов. Надаа тэр мэдээллийг нэг өгөөдхөөч. Тэгээд цаашид энэ олон чанаргүй сургуулиуд хүмүүсийн

мөнгийг авч 4 жилийг нь үрээд нөгөө хүмүүс нь ажлын байран дээр гараад шаардлага хангахгүй байна. Энэ дээр ямар бодлого баримтлах вэ гэсэн энэ асуулт байгаа юм байна. Энд нь хариулчих.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Тэгэхээр энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургалтын чанарын асуудлыг бид гүйцэтгэлийн үнэлгээг нь хийж үзсэн. 61 хувьтай байсан, хангалттай биш. Энэ 61 хувьтай гарсан энийг дээшлүүлэх шаардлагатай. Юуны тухайд бол тэр эрэмбийн эхний 5 сургуулиуд нь тайлан нь бол гарчихсан байгаа. Боловсролын үнэлгээний төвөөс гаргачихсан. Сургуулиудад нь хүргэсэн ийм байдалтай байгаа. Энэ дээр эхний 5 сургууль нь бол МУИС 1 дүгээрт. Тэгээд төрийн өмчийн. Би танд яг юугаар нь хүргэе? Эхний 5 сургууль МУИС, ШУТИС байсан. Анагаах билүү? Тийм 4 дүгээрт нь МУБИС байсан тийм. Тавд нь нэг хувийн сургууль орсон байх шиг байсан.

Энэ тоог танд дараа нь би хүргүүлье. Яамны зүгээс бол сум, аймаг, дүүрэгтээ хэрхэн ажиллаж байна вэ гэхээр энэ.

**Ч.Ундрам:** Нэмээд нэг минут өгчихье, уучлаарай.

**П.Наранбаяр:** Тэгэхээр энэ сум, аймаг дүүрэгт яамны зүгээс бид яг энэ боловсролынхоо босоо тогтолцооны шугамаар хамтран ажиллаж байгаа. Боловсролын ерөнхий газар бол аймаг. Аймаг болоод сумдын хэмжээнд ингээд харилцаад явдаг. Мөн Нийслэлийн боловсролын газартайгаа харьцдаг. Нийслэлийн боловсролын газар нь бол дүүргүүдтэйгээ ингээд харьцаад явдаг.

Томилгооны тухайд Алтаншагай гишүүний асуултад хариулахдаа хариулсан. Ер нь бол жишээлбэл сүү хөтөлбөр байна. Дундговь аймагт маш сайн хэрэгжсэн. Мөн Улаанбаатар хотын хүрээнд бол 4 дүүрэг дээр ч ингээд хэрэгжээд явсан. Энэ Засаг дарга, Боловсролын яам болоод бусад холбогдох байгууллагууд хамтран ажилласны үр дүн түүний зэрэгцээ цэцэрлэгийг 100 хувийн хамрагдалтай болгох зорилго тавиад энэ зорилгодоо хүрч чадсан нь орон нутгийн байгууллагатай сайтар хамтарч ажилласны бас.

**Ч.Ундрам:** Хариулт хангалттай юу? Бямбасүрэн гишүүнд нэг минут өгье.

**Ш.Бямбасүрэн:** Өнөөдөр Улаанбаатар хотод энэ утааны асуудал гээд л нэлээн өндөр асуудал болоод хүмүүст ер нь өвөл болгон л ярьж байна. Тэгээд энэ Засгийн газраас ер нь ингээд манай Монгол Улс бүсчилсэн хөгжлийн юугаар ингээд явна гээд үзэл баримтлалтай хөгжинө гээд баталчихсан. Тэгээд энэ орон нутгийн энэ их дээд сургуулиудыг ер нь чадавхжуулах энэ ер нь оюутнуудыг ер нь бүсчилсэн байдлаар тэнд нь сургах тийм ер нь ямар нэгэн бодлого байна уу? Одоо жишээлбэл манай Дорнод аймагт бол Дорнод Их сургууль гэж хуучин байж байгаад одоо бол МУИС-ийн харьяа сургууль болчихсон байж байгаа.

Тэгэхдээ нөгөө нэг чанарын асуудлаас нь болоод байдаг юм уу, ерөөсөө тэнд нөгөө нэг элсэн суралцагчдад аягүй бага байдаг. Уг нь бол тэнд нь бааз нь байдаг, материаллаг бааз нь байшин барилга нь байж байдаг, дотуур байр нь байж байдаг. Зүүн бүсийнхээ оюутнуудыг сургаад явах бүрэн боломжтой тийм сургууль байгаад байдаг. Тэрийг бид нар яаж хөгжүүлэх ёстой юм бэ? Тэрэн дээр ер нь яам ер нь ямар бодлого баримталж байна?



#### **Ч.Ундррам:** Наранбаяр сайд.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дотор орсон байдаг. Ер нь бол баруун, зүүн, төвийн, хангайн гээд ингээд бүсүүд дээрээ говийн бүс гээд. Энэ бүсүүд дээрээ кластераар их дээд сургуулийн кластерыг бий болгож энэ дээрээ оюутнуудыг хүлээж авах энэ оюутны тоотой нь хүртэл хийчихсэн судалгаа байдаг. Жишээлбэл баруун бүст гэхэд 5 мянга. Энэ Дархан-Уул аймагт бол 5 мянга, Хөшигтийн хөндийд бол 22 мянган оюутан гэсэн ийм бодлого бий. Өнөөдөр яг бас шууд тодорхой явж байгаа нэг бодлогыг дурдахад бол энэ орон нутгийн их дээд сургууль, коллежуудад суралцсан тохиолдолд боловсролынх нь төлбөрийн, сургалтын төлбөрийн 50 хувийг нь шууд ингээд зээлээр олгож байгаа ийм бодлого байгаа. Ингээд 50 хувийг нь шууд хөнгөлж байгаа. Тэгээд тэр тухайн оюутан өөрөө хүсэх юм бол 50 хувийнхаа хөнгөлөлтийг эдлээд дараа нь 50 хувийн зээл аваад ингээд төгсөж болох энэ бодлого өнөөдөр хэрэгжээд явж байна.

**Ч.Ундррам:** Түрүүн энэ Алтаншагай гишүүний нөгөө нэг иргэний гомдлын талаар ярьсан шүү дээ та СУИС-тай холбоотой. Тэгэхээр энэ дээр яам, дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газар байгаа. Та хэрвээ өргөдлийг нь дамжуулчихвал шууд тэндээ ажлын хэсэг гаргаад явуулж болно гэж би бодож байна л даа. Тэгээд ер нь бол багш хүнд хичээл заагаад хэд хэдэн удаа нөгөөдөх нь дахиж хичээлээ сонгоод төгсөж чадахгүй байгаа бол тэр багшийн хичээлийн чанар ч гэсэн яригдана шүү дээ. Хүнд ойлгомжтой юм зааж чаддаггүй хүн байна гэсэн үг. Нөгөө талаасаа бас харах ёстой.

Тэгэхээр энэ дээр бид нар одоо бас яг манай Монгол Улсад энэ чинь бас тодорхой байдаг асуудал байхгүй юу. Ингээд дүнгээр боодог, хүүхдийг дүнгээр хавчиж төгсгөхгүй. Тэгээд заавал үзэх ганц хичээлийг нь ингээд бариад базаад суучихдаг ийм багш нар байдаг юм шүү дээ. Энийг бол энэнээс салах ажлыг манай МУИС дээр бид нар хийж байсан. Одоо ийм юм байхгүй болсон. Нэг хичээлийг 2 хүн заадаг, тэрийг багшаа хүүхэд сонгодог сонголтыг бид нар өгдөг болгож байсан.

Тэгэхээр энийг бол бүх их сургуулиуд хэрэгжүүлэх ёстой. Нэг хүний субъектив нөлөөллөөс болж хүүхэд хохирох ёсгүй гэж бодож байгаа.

Бум-Очир гишүүн асуулт асууя.

**Д.Бум-Очир:** Баярлалаа. Хөтөлбөр, төлөвлөгөө шинэчлэгдэж байгаа юм байна. Миний ойлгосноор эхний ээлжид бага ангийн туршилтын сургалтын төлөвлөгөө явж байгаа юм байна аа. Үүнтэй холбогдуулаад нэг асуулт байна. Энэ дээр бол яах вэ бага ангийн туршилтын төлөвлөгөөний загвар ирчихсэн байна, баталчихсан байгаа юм байна. Дунд ангийнх, ахлах ангийнх хийгдээгүй байгаа гэж ойлгох уу? Бас үзэж танилцмаар санагдаж байна. Бага ангийнх дээр бол 9 хичээл байна. 8-9 хичээл. Энэ дотор компьютерын ухаан гэж байна. Жишээ нь ер нь бол миний асуух гээд байгаа гол зүйл бол хичээлийн тоо юм аа. Тэгээд энийг бид нар их олон удаа ярьсан бүгдээрээ мэдэж байгаа. Манайх бол хамгийн олон хичээлтэй улс орон хараахан биш гэдгийг та бүхний өмнөх танилцуулгууд харуулж өгсөн. Гэхдээ манайх бол олон хичээл заадаг улсдаа орж байгаа. Зарим нь дунджаас дээгүүр энэ тэр байгаа байх. Тэгэхээр цаашдаа бид ер нь энэ хүүхдүүдийн үзэж байгаа хичээлийн тоог цөөлөх тийм бодлого яамнаас барих уу? Тийм боломж бий юу гэдгийг нэгд тодруулмаар байна.

Хоёрт нэгэнтээ хөтөлбөр төлөвлөгөө ярьж байгаа учраас агуулгын давхардлыг арилгах эс үгүй бол агуулгыг илүү компактный гэх юм уу товч тодорхой болгох байдлаар зохион байгуулах боломж юу байна аа? Миний ойлгож байгаагаар бол тодорхой хэмжээгээр агуулгын давхардал байгаад байх шиг байгаа юм. Энэ бол мөн хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичигтэй хамаатай зүйл болж хувирах болов уу гэж бодож байна.

Дараагийн нэг зүйл юу вэ гэхээр энэ хөдөө орон нутагт ялангуяа суман дээр багш нарын 19 цаг хүрэхгүй байгаа 7 хоногтоо. Та бүхэн мэдэж байгаа. Би энийг урьд нь зөндөө ярьж байсан. Өнөөдөр МУБИС-ийнхантай бид нар өглөө уулзсан. Тэгээд хос мэргэжлийн код яамнаас гарах ёстой. Жишээ нь хими, биологийн багшийг зэрэг бэлдэнэ. 5 жил юм уу? 5.5 жил юм уу? 6 жил юм уу гээд ингээд хуваарь гарах ёстой. Тэгэхээр энэ хос мэргэжилтэй багш нар маань хөдөө орон нутагт ялангуяа ажиллавал тэр 19 цаг нь хүрэх хүрэхгүй тухай асуудал болох юм биш үү юу гэдэг юм хүргээд ажиллах боломжтой болох юм шүү.

Тэгэхээр яамнаас хос мэргэжлийн индекс гэж ойрдоо гарах уу? Энэ дээр ажиллаж байгаа юу гэдэг ийм асуудал байна.

Гуравдугаарт 3 улиралтай болгочихсон. Тэгээд энэний маань ач гэх юм уу ашиг тус харагдаж байна уу маш их хэл ам дагуулсан. Одоо бол багш нар 3 байх шаардлага байгаа юм уу үгүй юм уу гэдэг ийм зүйл яриад байгаа.

**Ч.Ундрэм:** Наранбаяр сайд.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Энэ өнөөдөр бага сургуульд 10 төрлийн хичээл орж байсан нь 9 болж цөөрч байгаа. Хичээлийн тооны тухайд ерөнхийдөө дэлхийн дундажид л явдаг. Дунд сургууль руу ороод ирэхээр 19 төрөл болж байгаа. Тэгэхээр бид бас энийг цөөлөх боломжтой гэж харж байгаа. Дараагийнхаа энэ юугаар шинэчлэлээ хийгээд явахдаа ингэж хийж болно гэж. Агуулгын давхардлыг арилгах нь бас зүйтэй. Таны хэлээд байгаа үнэн. Хос мэргэжлийн кодын тухайд бол энэ бид бас 2024 онд гаргасан энэ журмаараа хос мэргэжлийн кодыг бол яг оруулсан байгаа. Мэргэжлийн боловсрол дээр ч дээд боловсрол дээр ч байж байгаа.

Тэгэхээрээ сургуулиуд өөрсдөө энийгээ сонгоод аваад явах боломжтой. 3 улирлын бүтцэд оруулсан нь бол энэ 2 дахь удаагийнх нь тохиолдол юм аа. Бас нэг оруулсан шүү дээ уржнан жил. Тэгээд энэ юуг онилсон бэ гэхээр яг ид энэ ханиадны үе хүйтрэлтийн үе ингээд эхлэхэд яг урт хугацааных нь өвлийн амралт нь эхэлж байдгаар ингэж оруулж ирж байгаа. 10 сард завсарт нь бие даалтын 7 хоног гэж оруулж ирсэн. Энэ бол нөгөө танхимын хичээл биш гадуур хүүхдийг авч явж үзвэр үзүүлэх тэгээд багш өөрийнхөө чөлөөтэй хөтөлбөрөө хэрэгжүүлэх эд нар гээд яг бид чиг чиглэл өгсөн л дөө. Тэгэхээр энэ дээр эхний хэрэгжүүлж үзсэн гэхэд зарим хэмжээнд амжилттай хэрэгжив үү гэж харж байгаа. Мэдээж шүүмжлэлүүд гарч байгаа. Илүү нарийн чиглэл өгөх ёстой байсан гээд энийг хүлээж авч байгаа.

Тэгэхээр ингээд 12 сарын 23-ны 1 дэх өдөр гэхэд амраад эхэлчихнэ. 21-ний хагас сайнаас үндсэндээ ингээд сургууль руугаа ирэх шаардлагагүй болно гэсэн үг. Тэгэхээр бас энэ 3 улирлын бас ач холбогдол нь ойлгогдож эхлэх болов уу гэж бодож байна. Энэ дээр ингээд 1 сарын 27-ны өдөр хүртэл ингээд урт хугацаанд амарч байгаа. Ийм байгаа. 4 улирлын тогтолцоотой байхаар яг ид хүйтрээд ирэхээр дахиад хичээл нь эхлээд ид ханиад томууны дэгдэлт их болчихсон үед хичээл

эхлээд дахиад л гэнэтхэн карангилах эсвэл гэнэтхэн цахим сургалтад орох гэсэн ийм л байдлаар явж ирсэн. Энэ нь бас өөрөө хичээлийн хоцрогдлыг бий болгох сургуулийн хэвийн үйл ажиллагааг дутагдалд оруулах ноцтой ийм байдлыг үүсгэдэг байсан. Гэнэтийн гэнэтийн шийдвэр бол энэ боловсролын салбарт бас их тийм сайнгүй. Тэгэхээр зэрэг энэ жил бол бүр 7 сард энэ 3 улирлын бүтцийг зарлаж бүх багш нартаа бүх сургуулиуддаа ойлгуулсан байгаа. Мэдээж шүүмжлэл гарна харъя.

Шүүмжлэлээ харж байгаад ингээд өнөөдрийн энэ нийгмийнхээ энэ өнөөдөр болоод байгаа энэ үйл явцтайгаа зохицож явахаас өөр арга байхгүй байна л гээд ингэж харж байна. Иймэрхүү байна. Баярлалаа.

**Ч.Ундрам:** Хос мэргэжлийг ярьсан уу?

Нэмж асуух уу? Тодруулж.

Би 2 асуулт асуух гэсэн юм.

Нэгдүгээрт, Итгэл даргаас энэ сургалтын хөтөлбөр бол манай энэ Боловсролын багц хууль, боловсролын реформыг хийсэн энэ хуулийн хэрэгжилтийн хамгийн гол цөм нь хөтөлбөр. Энэ хөтөлбөр бол манай Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийг ямар мэдлэг, чадвар, дадалтай, ямар итгэл үнэмшилтэй хүмүүс болох вэ гэдгийг тодорхойлох зүйл байгаа. Тэгээд одоо бид нарын өмнө ярьснаар 1 дүгээрт Монгол хүн байх ёстой. Эх хэл, түүх соёлоо мэддэг, ахуй ёс заншлаа мэддэг. Тэгээд биеийн тамирын хичээл гэхэд эрийн 3 наадмаа мэддэг. Тиймээ заримыг нь хийж сурдаг, Монгол хоолоо мэддэг. Үүний дээр дэлхийн иргэн байх ёстой. Англи хэлтэй, шинжлэх ухааны хичээлүүдийг маш сайн мэддэг ойлгодог, софт скиллс гэж ярьдаг харилцааны соёлоос авхуулаад ийм мэдлэг чадвартай хүмүүс байх ёстой гэсэн ийм зүйлийг бид нар өмнө нь ярьсан. Тэгэхээр яг одоо энэ хичээлүүд, хичээлүүдийн агуулга руу чинь эдгээр зүйл энд сууж өгсөн үү? Бүрэн сууж өгсөн үү? Дараа нь 10 жилийн дараа манай Монголын үр хүүхдүүд ийм болчихжээ гээд эргээд үр дүн гарна шүү дээ. Тэгэхэд одоо энэ ажлын хэсэг чинь бүрэн хариуцлага хүлээх үү? Энэ бүгдийг хийж чадах чадамжтай хүмүүс ажлын хэсэгт чинь ажиллаж байна уу гэсэн ийм асуулт байна.

Хоёр дахь нь болохоор Гантуяа даргаас ЭЕШ-тай холбоотой би олон жил ярьж байгаа. Хүүхдийн хувь заяаг энэ шалгалт шийддэг юм. Дээд боловсролтой байх юм уу үгүй юу. Аль их сургуульд орох юм бэ? Тэр хувь заяаг. Тэгэхээр энэ хувь заяаг нь нэг өдрийн дотор шийдээд чи чадахгүй юм байна гээд шийдэж болохгүй ээ. Тийм учраас олон улсад SAT, ST гээд шалгалтуудыг эсвэл TOEFL-ийг ч гэсэн олон удаа өгч болдог. Магадгүй тэр хүүхэд 11 дүгээр ангидаа өгөөд үзье гээд өгөөд үзэх боломж нь нээлттэй байх ёстой. Нэмэлт зардлаа төлж болно шүү дээ. Нэмэлт зардлаа төлөөд тэгээд өгөөд ядаж энэ шалгалтыг өгч үзэх цочроо нь гарна. Туршлагатай болно, бэлдэх ямар чиглэлээр бэлдэх ёстой юм бэ гэдгээ ойлгоно. Тэгээд дараа сар нь дахиад өгч болдог гадаадад. Дахиад мөнгөө төлөөд өг. Ингэсээр байгаад хүүхдэд сайжрах боломжийг нь өгч байх ёстой. Захиалга авдаг байхгүй юу. SAT шалгалтыг манай сургуулиас 10 хүүхэд өгье гэж байна. Энэ зардал нь байна гээд. Тэгээд очоод зохион байгуулаад л өгчихдөг. Тэгээд хүүхэд өөрийнхөө хүссэн тэр хэмжээндээ хүрчих юм бол тэгээд одоо боллоо, би сургуульдаа энэ энүүгээрээ орно гээд л болчихдог. Ийм боломж.

Хоёрдугаарт агуулга байгаа. Энэ ЭЕШ-ыг ингээд дандаа хичээл сэдэвчилсэн байдлаар аваад байдаг болохоор ахлах ангитай хүүхдүүд байгалийн ухааны хичээл бүүр сонгохоо больчихсон. Тэгээд МУБИС дээр байгалийн ухааны багш орохгүй тэрнээс болоод байгалийн ухааны багш нар бэлтгэгдэж гарахгүй байна шүү дээ. Тэгээд бүгдээрээ багаасаа багш нар нь ч гэсэн чи тоондоо муу юм чинь физиктээ муу юм чинь нийгэмдээ бэлдээрэй гээд тэгэхгүй миний гүйцэтгэл муу гарах гээд байна гээд ингэчихдэг. Тэгээд хүүхдийн эрхэд халдаад. Тэгэхээр ерөнхий 12 дугаар анги төгсөж байгаа хүүхэд ийм мэдлэг чадвартай байх ёстой гээд ерөнхий агуулгаар авах ёстой. Тэгээд магадгүй инженерийн ангид орох гэж байгаа хүүхэд тэр тоогоо илүү гүнзгийрүүлсэн нэмэлт шалгалтаа дахиад танай үнэлгээний төвд захиалга өгөөд өгөөд тэгээд инженерийн сургуульдаа ордог ч юм уу ийм олон улсын тогтолцоо руу бид нар ормоор байна аа.

Дээрээс нь энэ бас Сурагчдын холбоо гэж хүүхдүүд байна. Уулзсан. Асуултууд нь ойлгомжгүй, тэр чинь маш богино хугацаанд амьдралаа шийдүүлэх гээд асуултдаа хариулж байгаа хүүхдүүд байна шүү дээ. Асуулт нь маш ойлгомжгүй. Тэр өгүүлбэртэй бодлого нь алдаатай, ийм маш чанаргүй шалгалтын материал боловсруулдаг гэж байгаа юм. Энэ шалгалтын материалыг бүтэн юу гэдэг юм жил боловсруулмаар байгаа байхгүй юу. Тэгэхдээ задруулахгүйгээр. Тэгэхгүй 7 хоног зочид буудалд аваачиж түгжээд тэгээд тэрэн дотор хэлдэг юм шүү дээ багш нар. Бүүр сүүлдээ толгой нь өвдөөд зарим нь архи уугаад тэгж байсан удаа ч байдаг.

Тэгэхээр бүтэн жил судалгаа шинжилгээнд тулгуурлаад яг энэ үнэлгээ гэдэг юмыг яаж хийдэг юм тэр арга зүйгээр нь боловсруулмаар байгаа юм. Энэ бол Монголын мянга мянган хүүхдийн амьдралыг шийддэг үнэлгээ байхгүй юу. Тийм учраас энэ чиглэл рүү хийж төлөвлөж байгаа ажил байна уу гэсэн ийм 2 асуулт. Итгэл дарга 2 номер.

**М.Итгэл:** Тэгэхээр манайх 2024 оны 4 сард энэ сургалтын сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал гэдэг Засгийн газраар батлагдсан. Энэ дээр Монголд суралцагчийн эзэмших чадамж гэж ийм 6 чадамж байгаа. Ерөнхий чадамж нь бүтээлчээр шүүн тунгаах сэтгэлгээтэй одоо суралцах арга барилтай гээд ингээд ийм яг ийм хүнийг л чадамжтай хүнийг бэлтгэнэ гэдэг энэ концепцын доор бүх хичээлүүд ямар байдалдаа хувь нэмэр оруулах вэ гэдэг чиглэлээр бол энд явж байна. Тухайлбал бас нэг зүйлийг энд нэмэхэд тэгэхээр яг энэ ерөнхий чадамжтай холбоотойгоор суралцахуйн агуулгын хүрээ гэдэг зүйл гараад тэрэн дээрээ сууриалаад хичээлээ бид нар бол гаргаж ирснээр бол хичээлийн тоог бол багасгах шийдлүүд энэ олон улсын туршлагын хүрээнд бол явж байна. Сая сайд сая ярьсан. Өөрөөр хэлбэл 10 хичээл 9 болсон. Өөрөөр хэлбэл бүр нарийн ярих юм бол компьютерын ухаан англи хэл гэдэг хичээл орж ирээд 9 болж байгаа юм.

Тэгэхээр бид нар бол интеграцчилж өөрөөр хэлбэл энийг бол нэлээн ийм агуулгыг нягтралжүүлж багасгаж байна гэж бодож байна. Мөн дунд болон ахлах боловсролын сургалтын төлөвлөгөө багууд байгуулагдаагүй учраас боловсруулагдаад явж байна. Тэгээд шийдлийг гаргах юм бол та бүхэнд хүргүүлнэ ээ. Баярлалаа

**Ч.Ундрам:** Наранбаяр сайд нэмээд.

**Ч.Наранбаяр:** Энэ үнэхээр сургалтын хөтөлбөр сурах бичиг таны бол хэлсэнчлэн яг энэ бол улс орны ирээдүйг авч явах хүнийг бий болгодог. Тухайн үедээ ямар сурах бичиг үзэж байсан тэр бидний бүүр тархины гүнд суучихсан л байдаг юм шүү дээ. Тэгээд тэр үед юу хэн юу ярьж байсан гээд энэ бүх юм чинь ингээд хүнийг бий болгож байдаг. Тэгэхээр энэ асар их хариуцлагатай ажил. Ийм учраас энэ хуулиар бас олгосон юуны дагуу Боловсролын үндэсний зөвлөл дээрээ бас энэ сурах бичиг болоод өнөөдөр энэ хөтөлбөрийн энэ төслийг бас хэлэлцүүлэхээр ингэж бэлтгэл ажлыг хангаж байгаа. Мөн Байнгын хорооны гишүүдээс санал авахын тулд өнөөдрийн төслийн хэлбэрээр боловсруулагдчихаад байгаа сурах бичгүүдийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Цаашдаа ер нь бид барьж байгаа бас нэг бодлогын тухайд бол унших чадвар үнэхээрийн сул байгаа учраас унших бичиг гэдэг энэ сурах бичгийг бол шинээр нэмж оруулж ирж байгаа унших бичиг зайлшгүй байх хэрэгтэй юм байна лээ. 2 дугаар ангиасаа орж ирж байгаа. Тэгээд мөн компьютерын ухаан байна. Англи хэл байна. Үнэхээрийн цаашдаа 21 дүгээр зууны сүүлчийн хагас хиймэл оюун ухаан өнөөдөр бол үндсэндээ хүн төрөлхтний хүнээс өөр хийж чадахгүй гэсэн энэ ажил мэргэжлийн юмыг ч гэсэн хийдэг болж эхэлж байгаа энэ үед үнэхээрийн ийм сургалтуудыг оруулахгүйгээр манай боловсрол урагшаа явахгүй юм байна гэсэн ийм ойлголт байгаа юм.

Харин зарим нэг ингээд шүүмжлэлүүд эд нар ирж байгаа. Цагаан толгой жишээлбэл үндэсний агууламж нь их өндөр байна гэсэн бас нэг ийм шүүмжлэл ирсэнд би бас нэг талдаа баяртай байгаа. Юу вэ гэхээрээ зэрэг энэ уламжлалаа Монгол хүн бүтээх гэсэн, бий болгох гэсэн, энэ юугаа бас чиг баримжаагаа барьж байгаа гэдэгт. Нөгөө талдаа бас зураг дизайны хувьд болохгүй байна үсгийн байрлал юмнууд болохгүй байна гэсэн техникийн шинжтэй тэгэхдээ энэ цаанаа сурганы их нарийн ийм асуудлыг хөндсөн шүүмжлэлүүдийг хүлээж авна. Энэ бол үнэхээрийн тийм. Тэгэхээр бид бас энийг цааш нь сайжруулах шаардлагатай гэж бодож байгаа. Сая бас яамны зүгээс энэ сурах бичгүүдийг туршцыг юу гэдэг юм нийцлийг нь ингэж үзэж байгаа сургуулиудаар өөрсдөө явж үзсэн байгаа. Англи хэл зааж байгаа тэр газруудаар нь очиж бүгдийг нь үзсэн байгаа. Энэ дээр бас тодорхой тайлан юм гараад ирэхээр нь Байнгын хороотойгоо бас хуваалцъя.

Үнэхээрийн энэ сурах бичгийн асуудал бол өөрөө ийм ирээдүй бий болгодог. Ийм маш чухал, зарим хэмжээнд үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүртэл яригдах ийм асуудал учраас бид энэ дээр бол маш их болгоомжтой түүний зэрэгцээ их хүлээцтэй түүний зэрэгцээ судалгаатай бас хандаж байгаа энэ хөтөлбөр мөн одоо сурах бичиг хийхээсээ өмнө үзэл баримтлалыг Энх-Амгалан сайдын үед бол Боловсролын үндэсний зөвлөлөөрөө хэлэлцээд, дэд зөвлөлүүдээрээ хэлэлцээд түүний дараа форум зохион байгуулаад СТӨ-нд тиймээ ингээд бүгдээрээ нийлж ярилцаж байгаад баталж гаргаж байсан. Яг энэ хүрээндээ л энэ өнөөдрийн энэ хөтөлбөрүүд сурах бичгүүд явж байгаа. Тэгэхээр бас яах вэ төрийн бас бодлогын залгамж чанар холбоо байгаа гэдгийг танд бас тайлбарлаж хэлье. Баярлалаа.

Гантуяа дарга 4 номер.

**Г.Гантуяа:** Дахин асууж байна уу? Энэ өвлийн шалгалт дээр би яг бүх процесс дээр нь ажиглалт хийсэн байгаа. Манай элсэлтийн шалгалт яг хүүхдүүдийн хариуг унших процесс дээрээ л автоматжуулалт байгаа боловч бусад бүх юм нь гар аргаар маш нүсэр бүтэцтэй. Зуны шалгалт гэхэд л маш өндөр өртөгтэй, өвлийнх нь

бага хүүхэд ордог мөртөө бас өндөр төсөвтэй. Хэрвээ бид нар улирал тутамд хүүхэд авдаг болгоё гэвэл энэ гар арга ажиллагаатай төсвөө л нэмээд байх юм. Тэгэхээр бид нар илүү цахимжуулалт руу явъя гэдэг бодлого барьж байна. Ялангуяа даалгаврын сан гээд. Бид нар элсэлтийн шалгалтын бодлогыг бол тэр нэг амралтын газар 30-45 хоногийн дотор багш нарыг өндөр тагнуулын харуул дор ингээд өдөр шөнөгүй ажиллуулаад энэ хүний эрүүл мэнд, хүний эрхийг зөрчсөн ийм үйлдэл байдаг юм байна аа. Тэгээд бид хэд бол одоо ер нь хамгийн түрүүнд энэ даалгаврын санг бид нар автоматжуулаад, даалгаврын сан дор хаяж 5 мянган даалгаврын сантай. Тэрнээсээ рэндомоор очдог. Тэгээд энэ дээрээ ухаалаг шийдлүүдийг оруулъя гээд ажлын хэсэг байгуулж эхэлж байна. Энэ тохиолдолд бид нар бол элсэлтийн шалгалтыг уян хатан хүн улиралд хэдэн удаа ч эс үгүй бол захиалгаар ч юм уу өгөх боломж бол байх болов уу гэж харагдаж байна аа.

Дараагийнх нь болохоор бид нар зохион байгуулалтыг бол нэлээн бас автоматжуулъя гэж бодож байна. Бас монгол хэл бичгийн бичгийн шалгалт өөрөө уламжлалт аргаар орж явж байгаа. Тэгэхээр бас их нүсэр гар ажиллагаа байгаа. Тэгэхээр бид нар ер нь цаашаа технологи руу яаж шилжих вэ гэдэг л стратегийг энэ дунд хугацаандаа нэвтрүүлнэ ээ. Мөн одоо энэ юу гэдэг юм элсэлтийн шалгалттай холбоотой гомдол, асуудлыг шийдвэрлэхдээ одоо бас манайх гар аргаар явж байгаа. Энийг бол бид нар бас олон улсын стандартын дагуу дуудлага хүлээх төвөөр авдаг ийм алхмуудыг хийнэ гэсэн зорилго тавиад явж байна.

Оюунаа дарга тэр нөгөө 2026 онд бид нар энэ элсэлтийн шалгалтынхаа загварыг өөрчлөх дээр нэмэлт тайлбар өгнө.

**Ч.Ундрэм:** Агуулга дээрээ тиймээ? Нэг номерын микрофон.

**П.Оюунаа:** Ундрэм гишүүний агуулгатай холбоотой хэсэгт би хариулт өгье. Элсэлтийн шалгалтын журам шинэчлэгдэж байгаа. Энэ журмаар бол 2026 оноос эхлээд элсэлтийн шалгалтад нэлээн өөрчлөлт оруулна. Энэ өөрчлөлтийг оруулахдаа сайт хэлбэрийн нэг шалгалтыг оруулж ирж байгаа. Энийгээ суралцах ур чадварын шалгалт гэж бид нар нэрлэсэн. Тэгэхээр суралцах ур чадварын шалгалтыг харьцангуй олон удаа өгдөг байхаар. Ялангуяа их дээд сургуульд суралцах ур чадварыг хэмжих чиглэлийн ийм агуулгатай байхаар төлөвлөж байна. Тэгэхээр энэ агуулгад яг ийм байдлаар энэ үнэлгээг олон удаа хийдэг. Тэгээд сайт хэлбэрийн шалгалттай болохын тулд бид нар одоогоос нэлээн бэлтгэл хангахгүй бол жишээлбэл дандаа судлагдахуунд суурилсан даалгавартай байсан үнэлгээний төв маань одоо эргээд суралцах ур чадварын даалгаврын үнэлгээ гэх мэтчилэн даалгаврын сангийн бэлтгэл хийх гэх мэтчилэн маш олон бэлтгэл хангах шаардлагатай байгаа.

Тэгэхээр 2025 онд бол бид нар энэ.

**Ч.Ундрэм:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байвал нэрсийг нь авъя. Үг хэлэх гишүүн байна уу? Эрдэнэбат гишүүн үг хэлье.

**С.Эрдэнэбат:** Түрүүн бас Наранбаяр сайдын ярианд цухас дурдлаа. Өмнө ч гэсэн нэлээн яриад хэл ам болоод эргээд больж байсан юм. Энэ боловсролын салбарын үйлчилгээний ажилчдыг хувийн хэвшлээр гүйцэтгүүлнэ гээд. Тэгээд энэ нь өөрөө эргээд нэлээн асуудал дагуулаад ний нуугүй хэлэхэд чимээгүйхэн ажлаа хийгээд явж байдаг хүмүүс. Хүүхдийн цэвэр байх, аюулгүй байх, тэгээд сургуулийн

болж бүтэхгүй нүдэнд харагддаггүй маш олон чиг үүргийг гүйцэтгээд явж байдаг хүмүүс байдаг юм. Тэгэхээр энийг хэт бас багахан мөнгөөр хувийн хэвшилд гүйцэтгэх ч газар бараг олддоггүй юм даа. Эргээд энийг нь ингээд хамаагүй мессеж өгчихөөр энэ ажлын байран дээр ирэх хүмүүс нь ирэхээ больчихсон. Одоо сургуулиудад тогооч байхгүй, үйлчлэгч байхгүй, харуул манаач хийх хүн олдохгүй гээд тун хэцүү байдал руу орох гээд байдаг юм.

Тэгэхээр энэ асуудлыг ер нь цаашлаад ийм бодлоготой байгаа энэ тэр гэдэг энэ зүйлийг маш сайн бодож байж тавихгүй бол энэ чинь бас нэг талаараа энэ салбарт ажиллаж байгаа хүмүүсийн нийгмийн хүлээлт. Тэгээд юун дээр тогтож ажилладаг юм гэхээр яах вэ хөөрхий тэтгэвэртээ гарахдаа нэг хэдэн сарын тэтгэмж авах дээрээ л бодож ажилладаг юм байна лээ. Тийм учраас энэ төрийн албан хаагч нарыг бас ажил албан тушаалаар нь ялгаварлах эд нарыг нь хувийн хэвшлээр нь гаргачихъя эд нарыг нь бол үлдээчихье гэдэг ийм байдал руу хэт явах бол энэ эргээд бас асуудал дагуулна аа. Маш олон хүмүүс бас санал хүсэлт ирүүлдэг юм. Яах вэ боломжтой газрууд нь тэрийгээ хийдэг юм байгаа биз. Гэхдээ боловсролын салбар дээр энийг бас нэлээн сайн үнэлж дүгнэж үзэхгүй бол эргээд сургалтын чанар аюулгүй орчин сургууль дээр байдаг маш олон ажлыг нугалж байдаг энэ ажлууд эзэнгүйд орхих ийм эрсдэл рүү бас дагуулах ийм асуудалтай шүү гэдгийг бас хэлмээр байна аа. Тэгээд энэ тал дээр бас жич бүр ингээд уулзаж ажиллая гэж бодож байна аа.

**Ч.Ундрэм:** Манай Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, харьяа агентлаг байгууллагууд ер нь энэ багшийн асуудал дээр нэлээн сайн анхаарах хэрэгтэй байна. Ажлын байрны зураглал хийгээд ер нь багш бэлдэхээс нь авхуулаад дараа нь ажлын байран дээр нь очихоор тэнд ямар их ачаалалтай байна мөн цалин урамшууллын яах ёстой юм. Тэгээд энэ боловсролын салбарыг дэмжье гэсэн маш олон Их Хурлын гишүүд байна шүү дээ. Энэ хүмүүсийн хүчийг бол бид нар 2026 оны төсөв дээр ашиглах бүрэн боломжтой. Одоогоос ярилцаад 2026 оны төсөв дээр ингэе ингэе гээд бүгд тохирчих юм бол маш том лобби бүлэг байгаа шүү гэдгийг дахин хэлмээр байна. Яг энэ салбарын төлөө бүүр ерөөсөө сэтгэл зүрхэнд зориулагдаад нойр нь хүрэхгүй ингээд над руу хүртэл хандаад бухимдаад явж байгаа хүмүүс зөндөө байгаа шүү.

Тэгэхээр та хэд маань сайн анхаарч ажиллаарай. Тэгээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан учраас хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

16.10 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА